

“НИЙГМИЙН” БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ



Хамт олонд түшиглэн сэргээн засах хандлагын

УДИРДАМЖ

ДЭМБ-ын Номын сангийн каталоги

Хамт Олонд Түшиглэн Сэргээн Засах Хандлага: ХОТСЗ хандлагын Удирдамж

1.Сэргээн засалт. 2.Хөгжлийн бэрхшээлтэй иргэн. 3.Хамт олонд түшиглэсэн эрүүл мэндийн үйлчилгээ. 4.Эрүүл мэндийн бодлого. 5.Хүний эрх. 6.Нийгмийн шударга ёс. 7.Хэрэглэгчийн оролцоо. 8.Удирдамж. I.Дэлхийн эрүүл мэндийн байгууллага. II.НҮБ-ын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Байгууллага. III.Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага. IV. Хөгжлийн бэрхшээл, Хөгжлийн олон улсын консорциум

ISBN 978 92 4154805 2

(NLM ангилал: WB 320)

© Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага 2010

Бүх эрх хадгалагдсан. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын хэвлэлийг WHO Press, World Health Organization, 20 Avenue, 1211 Geneva 27, Switzerland (tel: +41 22 791 3264; fax: +41 22 791 4857; e-mail: bookorder@who.int) -аас авч болно. ДЭМБ-ын хэвлэлийг орчуулах эсвэл дахин боловсруулж зарах эсвэл арилжааны бус байдлаар хэрэглэх алинд нь ч зөвшөөрөл авах ба ДЭМБ-ын Хэвлэлийн газарт дээр дурдсан хаягаар (fax: +41 22 791 4806; e-mail: permission@who.int) хандана.

Энэхүү хэвлэлийн дотоод агуулга нь Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын үзэл бодлыг илэрхийлэхгүй. Газрын зурган дээрх цэгэн зураас хилийг ойролцоогоор төлөөлсөн.

Үүнд дурдагдсан тухайн онцгойлсон компани эсвэл үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүн нь Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас зөвлөсөн эсвэл зөвшөөрсөн гэсэн үг биш.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага энэхүү хэвлэлд орж буй мэдээллийг баталгаажуулж бүх боломжит урьдчилан сэргийлэх аргуудыг авсан хэдий ч уг хэвлэлийг ямар нэгэн илэрхийлэл, зөвшөөрлийн баталгаагүйгээр тараасан болно. Орчуулгын хариуцлага болон уг материалыг ашиглах эрх нь уншигч танд буй. Үүнийг ашиглахад гарах ямар нэгэн хохирлыг Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага хариуцахгүй.

Хэвлэлийн дизайн, загварыг Inis Communication

www.iniscommunication.com

Мальтад хэвлэв.



Энэхүү товхимлыг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвшөөрөлтэйгөөр Дэлхийн Зөн Монгол Олон Улсын Байгууллагын “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн гэрэлт ирээдүй” төслийн санхүүжилтээр 600 хувь хэвлэв.

СЗСҮТ

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 7-р хороо, Эрхүүгийн гудамж, Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв
20-р салбар, Ш,х: №364
Утас:352423
Цахим шуудан: info@nrc.gov.mn
Цахим хуудас: www.nrc.gov.mn

АИФО

Холбоо барих хаяг:
АИФО байгууллагын Монгол дахь суурин төлөөлөгчийн газар
Улаанбаатар 210648, Ш,х:75
Утас: 70153058

Дэлхийн зөн

Холбоо барих хаяг:
Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 13-р хороолол, 15-р хороо, (133-70), Энхтайвны өргөн чөлөө, 49-р барилга, Соманг плаза, 4-р давхар, Улаанбаатар 15160,
Шуудангийн хайрцаг 705
Вэб: <http://www.wvi.org/mongolia>

Орчуулсан: М.Намсрайхүү, НЗДТГ-ын мэргэжилтэн,
нийгмийн ухааны магистр
Хянасан: Д.Тулгамаа, АИФО байгууллагын суурин төлөөлөгч, нийгмийн
ухааны магистр, докторант

ХАМТ ОЛОНД ТҮШИГЛЭН СЭРГЭЭН ЗАСАХ ХАНДЛАГЫН УДИРДАМЖ **“Нийгмийн” бүрэлдэхүүн хэсэг**

Агуулга:

Өмнөх үг.....	04
Хувийн туслалцаа.....	10
Холбоо харилцаа, гэрлэлт, гэр бүл.....	20
Соёл, урлаг.....	28
Амралт, чөлөөт цаг, спорт.....	36
Шүүх.....	44

Өмнөх үг

Хамт олон, гэр бүлийн амьдралд идэвхтэй оролцох нь хувь хүний хөгжилд чухал нөлөөтэй байдаг. Нийгмийн үйл ажиллагаанд оролцох нь хувь хүн өөрийгөө таниулах, өөртөө итгэлтэй байх, амьдралын чанар болон нийгмийн байдалд хүчтэй нөлөө үзүүлдэг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нийгэмд маш олон саадтай тулгардаг учраас нийгмийн амьдралд оролцох боломжоор хомс байдаг. Хамт Олонд Түшиглэн Сэргээн Засах /ХОТСЗ/ хөтөлбөрүүдийн ихэнх нь өмнө нь эрүүл мэндийн асуудал болон сэргээн засах үйл ажиллагаанд анхаарлаа хандуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хэрэгцээг үл хайхардаг байжээ. Өнөөдрийг хүртэл холбоо харилцаа, гэрлэлт, эцэг эх болох гэдэг дэндүү эмзэг, хэцүү сэдэв байсаар байгаа энэ үед урлаг, спорт, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, шударга шүүхээр шүүлгэх зэрэг үйл ажиллагааны талаар ярих ч шаардлагагүй мэт санагдаж байна. Энэ товхимол нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралд эдгээр асуудлууд чухал болж байгааг, мөн ХОТСЗ хөтөлбөр эдгээр асуудлууд руу анхаарлаа хандуулах хэрэгтэй байгааг онцлон харуулж байна.

Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хамт олон, гэр бүлийнхээ дунд утга бүхий нийгмийн үүрэг, хариуцлага хүлээж, бусдын адил нийгмийн нэгэн гишүүн байх

ХОТСЗ-ын үүрэг

Тус хөтөлбөрийн үүрэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг гэр бүл, хамт олны нийгмийн амьдралд бүрэн дүүрэн оролцуулахын тулд холбогдох гол хүмүүстэй ажиллах явдал юм. ХОТСЗ хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст нийгмийн харилцаанд оролцох боломжийг олгож, мөн нийгэмд эерэг өөрчлөлт бий болгох, ялгаварлан гадуурхалт, олон нийтийн дундах буруу ойлголтыг арилгахад дэмжлэг туслалцаа үзүүлж болно.

Хүсч буй үр дүн

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нийгмийн төрөл бүрийн үүрэг, хариуцлага хүлээдэг гэр бүлийн нэгэн үнэ цэнэтэй гишүүн гэж үнэлэгдэнэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийг хамт олны хөгжилд өөрийн бололцоо, ур чадвараа зориулахад нь урам зориг өгч, дэмжлэг үзүүлнэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгэмд эерэг хувь нэмэр оруулж чадах нийгмийн үнэ цэнэтэй гишүүн гэж хамт олон нь танина.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд нийгмийн харилцаанд оролцоход гардаг саад бэрхшээлийг шийдэх болно.
- Орон нутгийн удирдлагууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн үр өгөөжтэй нийгмийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

Жишээ 1 Мексик

Хамт олон оролцоог баталгаажуулсан нь

Пина Палмера нь Мексикийн Оаксакагийн өмнөд эрэгт оршдог төрийн бус байгууллага юм. Уг байгууллага нь 1989 оноос ХОТСЗ үйл ажиллагааг эхлүүлсэн бөгөөд одоо 7 аймагт идэвхтэй ажиллаж хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон тэдний гэр бүлийнхний өдөр тутмын хэрэгцээг мэдэхийн тулд маш нягт хамтарч ажиллаж байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгарч буй саад бэрхшээлийг арилгах, тэднийг хамт олны дунд хамруулахын тулд орон нутгийн удирдлагууд, багш, нийтийн тээврийн операторууд болон эмнэлэгийн мэргэжилтнүүдтэй нягт хамтарч ажилладаг.

Тус байгууллага нь ХОТСЗ хөтөлбөрийн нийгмийн бүрэлдэхүүн хэсгүүдийг тодотгосон олон арга хэмжээг явуулдаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон хүнд ба хавсарсан бэрхшээлтэй иргэдэд хувийн туслалцаа үзүүлдэг. Эдгээр туслалцааг байгууллагын ажилтнууд, сайн дурын идэвхтнүүд үзүүлдэг бөгөөд хувийн ариун цэвэр, орон нутагтаа зорчих, болон бусад нийгмийн үйл ажиллагаануудад туслалцаа үзүүлдэг. Мөн хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэд дээрх туслалцааг шаардлагатай үедээ авч, ажлаа үргэлжлүүлэн хийдэг байна.

Пина Палмера нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг спорт, өөрөө хичээллэх чөлөөт цагаа зөв зохистой өнгөрөөхийг нь дэмждэг. Тус байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй болон бэрхшээлгүй иргэд оролцох хамт олны үйл ажиллагаа зохион байгуулахад хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон орон нутгийн тамирчидтай хамтарч ажилладаг. Туслах хэрэгсэл болон спортын тохируулсан тоног төхөөрөмжүүд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг оролцох боломжоор хангадаг. Хэд хэдэн хөгжлийн бэрхшээлтэй иргэд тэргэнцэртэй иргэдийн үндэсний сагсан бөмбөгийн багт ороод байна.

Пина Палмера нь үр өгөөжтэй харилцаа холбоо, маргааныг шийдвэрлэх, багаар ажиллах, хүндлэх, хүйсийн тэгш байдал, бэлгийн амьдрал гэх мэт сэдвүүдээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж сургалт семинар зохион байгуулдаг. Эдгээр сургалтууд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгмийн цар хүрээгээ өргөжүүлэхэд тусалдаг. Пина Палмера нь шаардлагатай тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд шударга бус байдлаас өөрсдийгөө хамгаалах чадвартай болгох зорилгоор хууль эрх зүйн зөвлөгөө өгдөг.



Гол ойлголтууд

Нийгмийн үүргүүд

Нийгмийн үүрэг гэж юу вэ?

Нийгмийн үүрэг гэдэг нь тодорхой хариуцлага хүлээж, үйл ажиллагааг гүйцэтгэж байгаа хүний нийгэмд эзэлж буй байр суурийг хэлнэ. Гэр бүл (эхнэр нөхөр, ээж аав, эгч, ах, найз нөхөд), ажил (багш, фермэр, хамт олны ажилтан), өдөр тутмын ажил (хоол хийх, цэвэрлэгээ хийх), спорт амралт (хөл бөмбөгийн тоглогч, хөзөр тоглогч) болон хамт олон (сайн дурын ажилтан, хамт олны манлайлагч) гэх мэт харилцааг багтаасан олон төрлийн нийгмийн үүргүүд байдаг. Хүмүүсийн нийгмийн үүрэг хариуцлагад нас, хүйс, соёл, хөгжлийн бэрхшээл зэрэг хүчин зүйлүүд нөлөөлдөг. Хүмүүсийн нийгмийн үүрэг нь тэдний амьдралынх нь туршид өөрчлөгддөг бөгөөд хамт олон нь эдгээр шилжилт өөрчлөлтүүдийг чухал дадлага туршлага болгон тэмдэглэдэг.

Яагаад нийгмийн үүргүүд чухал вэ?

Нийгмийн үүргүүд нь амьдралын утга учрыг тодорхойлдог учир чухал байдаг. Хувь хүний нийгэмд эзэлж буй ялгаатай байр суурь нь тухайн хүний нийгмийн байдалд нөлөөлдөг. Жишээ нь эхнэр нөхөр, эцэг эх байх эсвэл ажил хийж цалин авдаг бол өндрөөр үнэлэгдэж нийгмийн байдалд нь эерэг нөлөө үзүүлж байхад харин ганц бие, хүүхэдгүй эсвэл ажил эрхэлдэггүй бол үнэлэмж нь багасч нийгмийн байдалд нь сөрөг нөлөө үзүүлдэг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст нийгмийнхээ үүргийг эерэгээр үзүүлэх боломж олдвол хөгжлийн бэрхшээлийн талаарх хандлага өөрчлөгдөнө. Жишээ нь: хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг энгийн сургуульд хамруулах эсвэл хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрэгчдийг ажилд оруулбал энэ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх нийгмийн хандлагыг өөрчлөхөд маш чухал түлхэц үзүүлнэ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн үүргээ биелүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс үнэ цэнэтэй нийгмийн үүргээ үнэ цэнэтэй амжилттай биелүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх хэд хэдэн арга байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн чадвар, чадамжийг дээшлүүлэх, нийгэмд тэдний талаарх эерэг төсөөллийг буй болгох болон хөдөлмөр эрхлүүлэх нь тэдэнд тусалж байгаа бөгөөд тэдний талаарх сөрөг хандлагыг өөрчлөхөд их үр дүнтэй юм.

Нийгэмд оролцоход тулгарч буй саад бэрхшээлүүд

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн оролцоог хязгаарлах өргөн хүрээний саад тотгорууд байна. Жишээ нь:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь өөртөө итгэлгүй, ямар нэг үйл ажиллагаа болон үйл явдалд оролцох чадваргүй гэж өөрийгөө боддог;
- Гэр бүлийн гишүүдийн хувьд хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй байх нь ичгэвтэр хэрэг бөгөөд тэдний нийгмийн оролцоог зөвшөөрч дэмждэггүй;

- Хамт олны гишүүд хөгжлийн бэрхшээлийн талаар өрөөсгөл бодол санаатай байдаг. Жишээ нь: хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ариун газрыг бузарладаг, тэд хараагдсан, тэднийг цэвэрлэх хэрэгтэй гэж үздэг бөгөөд тэдэнд далдын тайлбарлашгүй нүгэл хураагдсан байдаг гэх мэт;
- Кино театр, спорт талбайн барилга байгууламж болон тээврийн хэрэгсэл хүртээмжгүйгээс хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүс нийгмийн харилцаанд оролцоход нь саад болдог.

Жишээ 2

Оролцоонд нөлөөлөх хөдөлгөөний бэрхшээл

Нэг удаа бид театрт кино үзэхийг хүссэн боловч тэргэнцэртэйгээ орох боломжгүй байсан юм. Театрын суудлын урд талд хангалттай зай байхгүй байсан учир бид сандал дээр нь сууж чадахгүй байлаа. Бид хүмүүсээс гуйсан боловч хэн ч биднийг сонссонгүй.

Хүйсийн тэгш байдал

Буурай хөгжилтэй орны хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд нь ээж болох гэх мэт тодорхой нийгмийн үүрэг хүлээх боломжоор хязгаарлагдмал байдаг. Зарим гэр бүл хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг гэрээс гадуур ямар нэг нийгмийн үйл ажиллагаанд оролцохоос болгоомжилж урьдчилан сэргийлдэг. Хүйсийн тэгш байдал нь хөгжлийн нэгэн чухал асуудал боловч хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүд нь ихэвчлэн хөгжлийн гол хөтөлбөрүүдэд оролцож чаддаггүй. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд нь шийдвэр гаргах түвшинд идэвхгүй хамрагддаг. Хөгжлийн бэрхшээлтэй охид залуучуудын болон амралт, чөлөөт цагийн үйл ажиллагаанд бага хамрагддаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд

Хөгжих сурах боломж, эрмэлзлэл, хайр энхрийллийг хүлээж байдаг хөгжлийн бэрхшээлтэй, бэрхшээлгүй хүүхдүүдийн хувьд хайр энэрэлээр дүүрэн аюулгүй орчин их чухал байдаг. ХОТСЗ хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг нийгмийн амьдралд оролцоход нь саад бэрхшээл болдог нийгмийн сөрөг хандлага болон ялгаварлан гадуурхалтыг шийдэх, гэр бүлд нь дэмжлэг үзүүлэх мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрхийг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэдэг.



Энэ бүрэлдэхүүн хэсгийн элементүүд

Хувийн туслалцаа

Зарим хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст гэр бүл, хамт олны амьдралд оролцоход хувийн туслалцаа хэрэгтэй байдаг. Буурай хөгжилтэй оронд нийгмийн үйлчилгээ, тэтгэвэр, тэтгэмж хязгаарлагдмал үед гэр бүлүүд ихэнхдээ эдгээр тусламжаас үндсэн тэтгэвэр, тэтгэмжийг л хүртдэг. Албан ёсны сонголт хязгаарлагдмал үед ХОТСЗ хөтөлбөр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийн хувь хүний хэрэгцээнд тохирох хувийн туслалцааны төрөл бүрийн сонголтуудыг хүртээмжтэй болгох үүднээс хамт олны нөөц бололцоог ашиглаж болохыг энэхүү элементээр харуулж байна.

Холбоо харилцаа, гэрлэлт, гэр бүл

Харилцаа холбоо нь бүх хүнд хэрэгтэй байдгийн нэгэн адил хөгжлийн бэрхшээлтэй хүнд ч чухал асуудал юм. Энэ элементээр ХОТСЗ хөтөлбөр хөгжлийн бэрхшээлтэй хүнийг холбоо харилцааны талаарх нийгмийн үүрэг, хариуцлагаа эдлэхэд тусалж болохыг харуулна. Хамт олны гол хүмүүстэй хамтран ажилласнаар ХОТСЗ хөтөлбөр хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголтыг нэмэгдүүлж, сөрөг ойлголттой байгаа гэр бүл болон хамт олны хандлагыг өөрчилж, хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг аливаа хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэхэд тусалж чадна.

Соёл, урлаг

Соёл, урлагийн үйл ажиллагаанд оролцох нь хувь хүн хөгжихөд маш чухал юм. Хувь хүн өөрийгөө таних, мөн хувь нэмрээ оруулах боломж, мэдрэмжийг бий болгоход тус болно. Энэ элемент нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг гэр бүлийнхээ болон хамт олны соёл, урлагийн амьдралд оролцох боломжийг хааж байгаа саад бэрхшээлүүдийг олж, асуудалд хандах юм. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх буруу ойлголт, ялгаварлан гадуурхалтын эсрэг, хүн болгон өөр гэдгийг илэрхийлэх, мөн хүмүүсийг хамруулах, оролцуулах соёл, урлагаар дамжуулж илэрхийлж болно.

Амралт, чөлөөт цаг, спорт

Амралт, чөлөөт цаг, спортын үйл ажиллагаа нь хамт олныг нэгтгэж, сайн сайхан байлгах, эрүүл энх байлгахын чухал үндэс болдог. Энэ элемент нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс энэхүү үйл ажиллагаанд оролцох ашиг тусын талаар тодорхойлох бөгөөд мөн ХОТСЗ хөтөлбөр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг оролцуулах, хамруулах талаар хамт олны гол хүмүүстэй хэрхэн ажиллаж болох талаар практик санал өгсөн. Хөтөлбөр, үйл ажиллагааг боловсруулах, төлөвлөхөд орон нутгийн гол хүмүүстэй хамтран ажиллахын ач холбогдол нь тэд өөрийн өөрийн орон нутагт тохирсон хөтөлбөр, үйл ажиллагааг хийдэг гэдгийг онцлон тэмдэглэж байна.

Шүүх

Хамт олны бүхий л гишүүд тодорхой цагт шүүхэд хандаж болох юм. Орон нутгийн түвшинд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцид заасан эрхүүдээ эдэлж чадаж байгаа эсэхийг баталгаажуулах, одоо мөрдөгдөж байгаа хууль дүрмийг сайтар мэдэж байх нь чухал. Энэхүү элементэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хууль, эрх зүйн талаарх мэдлэгээ дээшлүүлж эрхээ эдлэх болон шударга бус явдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үйл явцад оролцоход нь ХОТСЗ хөтөлбөр хэрхэн тусалж болох талаар анхаарлаа хандуулсан.



Хувийн туслалцаа

Танилцуулга

Зарим хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст гэр бүлийн болон хамт олны амьдралд бүрэн дүүрэн оролцоход хувийн туслалцаа хэрэг болж болно. Орчны хүртээмжийн хүчин зүйлс (тухайлбал орчин хүртээмжгүй байх), мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдийн зорилго үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд саад болж буй биеийн согогийн болон үйлдлийн бэрхшээлтэй байгаа тохиолдолд хувийн туслалцаа шаардлагатай болж магадгүй юм.

Хувийн туслалцаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүн хүссэн үедээ босох, унтах, идэх, гэр ахуйн үүргийг гүйцэтгэх, гэрээс гадуурх нийгмийн үйл ажиллагаанд оролцох, боловсрол эзэмших, орлого олох, гэрийнхнийгээ асрах зэргийг боломжтой болгодог.

Хувийн туслалцаа нь албан бус буюу гэр бүлийн гишүүд, найз нөхдөөр дамжуулан, эсвэл албан хэлбэрээр буюу нийгмийн үйлчилгээ, хувийн ажилтнаар дамжин хүрч болдог. Албан ёсны туслалцаанд зориулах санхүүжилт нь бага болон дунд орлоготой орнуудад маш хязгаарлагдмал байдаг боловч Бразил, Энэтхэг, Өмнөд Африк, Бангладешийн засгийн газрууд нийгмийн хамгааллын тогтолцоогоо хөгжүүлж байна. Эдгээр тогтолцоонууд хөгжсөнөөр хувийн туслалцаа авах шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжихэд ХОТСЗ хөтөлбөрт илүү боломж гарна гэж найдаж байна (Амьжиргаа бүрэлдэхүүн: Нийгмийн хамгааллын хэсгийг харна уу).

Жишээ 3

Хөгжлийн Бэрхшээлтэй Хүмүүсийн Эрхийн тухай Конвенци, 19-р зүйл: Бие даан амьдрах болон тухайн оршин суугаа орчиндоо хамрагдах

Оролцогч улсууд нь энэхүү Конвенцид зааснаар хөгжлийн бэрхшээлтэй бүх хүн бусдын нэгэн адил нийгэм, хамт олон дотроо амьдрах тэгш эрхийг хүлээн зөвшөөрч, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс энэхүү эрхээ эдлэх явдлыг хангах, нийгэм, хамт олон дундаа бүрэн дүүрэн хамрагдаж оролцохыг дэмжих үүднээс дараах нөхцөлийг хангах замаар зохистой, үр дүнтэй арга хэмжээ авна:

а) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь бусдын нэгэн адил оршин суух газар болон хаана, хэнтэй амьдрах эсэхээ чөлөөтэй сонгох боломжтой байх ёстой бөгөөд тусгай нөхцөл байдалд амьдрах албагүй;

б) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст гэрийн, оршин суугаа газрын болон нийгэм, хамт олны бусад туслах үйлчилгээ, түүний дотор амьдрахад нь дэмжлэг болохуйц болон нийгэм, хамт олон дунд хамруулахад нь хувийн туслах үйлчилгээг авах боломжтой байх бөгөөд нийгмээс тусгаарлах, хөндийрүүлэхээс хамгаалагдана;

в) нийт хүн амд зориулагдсан нийгэм, хамт олны үйлчилгээ, хэрэгслүүд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бусдын нэгэн адил тэгш байх бөгөөд мөн тэдний хэрэгцээг хангахуйц байна.

Жишээ 4 Бүгд Найрамдах Солонгос улс

Шаардлагатай үед туслалцаа үзүүлэх

Жае-Хуан нь эмээ, эгч, 2 үеэлтэйгээ Сөүлд амьдардаг 13 настай хүү юм. Тэрээр 4 настай байхдаа булчин сулрах өвчинтэй хэмээн оношлогдсон. 9 настай байхдаа биеэ дааж алхаж, сургуульд явах боломжгүй байсан бөгөөд маш их гутардаг байжээ.

Тэрээр 13 настай байхдаа ХОТСЗ хөтөлбөрт анх хамрагдсан. Тэд Жаег эмнэлэгийн сэргээн засалт болон эмчилгээ хийлгэхээр Үндэсний сэргээн засах эмнэлэг рүү илгээсэн. Тэрээр Туслах Хэрэгслийн Судалгаа, Туслалцааны төвөөс тусгай суудалтай цахилгаан тэргэнцэр хүлээн авснаар нөхцөл байдал нь тогтвортой болж сургуульдаа эргэж явахыг хүссэн боловч хувийн туслалцаагүйгээр үүнийг хийж чадахгүй байв.

Тухайн эмнэлэгийн нийгмийн ажилтан нь Жаег их сургуулийн сайн дурын ажилтантай холбосон бөгөөд тэрээр Жаед дунд сургуулийн хичээлийн хөтөлбөрийг үзэж дуусахад нь туслалцаа үзүүлжээ. Мөн түүнтэй хамт 7 хоног бүр ном уншиж, зураг зурахад нь тусалдаг сайн дурын, орон нутгийн төрийн бус байгууллагатай холбосон. Түүний гэрийг нь тэргэнцэр ашиглахад тохиромжтой болгож тохижуулахад нь шаардлагатай туслалцааг үзүүлж, түүний ээжид нь цэвэрлэх гэх мэт гэр ахуйн ажилд нь туслах сайн дурын ажилтан байнга очиж байсан.

Мөн тэрээр Солонгосын Булчин Сулралтын Сангийн өөрөө өөртөө туслах бүлгийн гишүүн болсон.

ХОТСЗ хөтөлбөр, Үндэсний Сэргээн Засах Эмнэлэг, Солонгосын Булчин Сулралтын Сан, Туслах Хэрэгслийн Судалгаа, Туслалцааны төв болон бусад орон нутгийн төрийн бус байгууллагуудын хоорондын хамтын ажиллагаа сайн байсан учир Жае Хуаны нөхцөл байдал сайжирсан. Нийгмийн ажилтнууд болон сайн дурынхан түүнд хувийн туслалцаа шаардлагатай байгааг тогтооход чухал үүрэг гүйцэтгэсэн.



Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрийнхөө хэрэгцээ шаардлагад нийцсэн, аливаа үйл ажиллагаанд оролцох, хувийн туслалцаа авах боломжтой байх.

ХОТСЗ-ын хөтөлбөрийн үүрэг

ХОТСЗ хөтөлбөрийн үүрэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрийгөө тодорхойлж, эрхэмсэг амьдрахад шаардлагатай хувийн туслалцааг авч, түүнийгээ идэвхтэйгээр удирдахад нь дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хүсч буй үр дүн

- ХОТСЗ хөтөлбөр болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд орон нутагт нь тохирох чанар, стандартыг хангасан хувийн туслалцааны сонголтуудыг бий болгоход хамтарч ажиллана.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс тухайн оршин суугаа газартаа хувийн дэмжлэг авах төлөвлөгөөтэй болно.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хувийн туслалцааны хэрэгцээгээ удирдах чадвартай болгох сургалтанд хамруулна.
- Албан болон албан бус хувийн туслагч нарт аль алинд нь сургалт явуулна.
- Албан бус хувийн туслалцаа үзүүлдэг гэр бүлийн гишүүдэд дэмжлэг үзүүлнэ.
- Хямралын үед хариу үзүүлэх механизмууд нь гэр бүл болон хамт олны түвшинд байх ба хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг институтын буюу асрамжийн байгууллагад очихоос урьдчилан сэргийлнэ.
- • Хамт олон болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хамт олонд түшиглэсэн хувийн туслалцааны сонголтыг бий болгож, дэмжлэг үзүүлнэ.

Гол ойлголтууд

Асрамжийн газар ба Бие даан амьдрах

Өндөр хөгжилтэй орнууд олон арван жилийн турш “Асрамжийн газар”-аас “Бие даан амьдрах” тогтолцоо руу шилжсэн. Бие даан амьдрах гэдэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрөө бүгдийг хийнэ гэсэн үг биш юм. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бэрхшээлгүй хүмүүсийн нэгэн адил сонгож, хянаж амьдарна гэсэн үг юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь өөрсдийнхөө хэрэгцээ шаардлагыг тодорхойлох хамгийн сайн мэргэжилтэн учир тэд амьдралаа өөрөө хариуцаж, ярьж, бодож чадах ёстой. Хувийн туслалцаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг асрамжийн газраас бие даан амьдрах боломжинд шилжих түлхүүр үйл ажиллагаануудын нэг юм.

Жишээ 5

Бие даан амьдрахад зориулсан хувийн туслалцаа

Бие даан амьдрах хөдөлгөөн нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг өөрийн соёлынхоо хүрээнд садан төрөл, найз нөхөд, хөрштэйгөө адил түвшинд бие даан амьдрах хэрэгтэй гэдгийг ухуулдаг олон улсын хөдөлгөөн юм. Энэ нь ялангуяа хувцаслах, бие засах, идэх гэх мэт өдөр тутмын үйл ажиллагаанд бусдын дэмжлэг зайлшгүй хэрэгтэй байдаг, тусламж нэн шаардлагатай хүмүүст хэрэгтэй байдаг.

Бие даан амьдрах хөдөлгөөнийхөн дээр дурдсан үйл ажиллагаанд хэрэглэхдээ хэрэв тухайн хувь хүн ямар үйлчилгээг хэн, хэзээ, хэрхэн авахаа шийдэж чадаж байвал “хувийн туслалцаа” хэмээх нэр томъёог хэрэглэдэг. Энэ нь тухайн хэрэглэгч уг үйлчилгээг өөрийн сонголтын дагуу үйлчилгээ үзүүлэгчээс худалдан авах, эсвэл өөрийнхөө сонголтыг гүйцэлдүүлэх туслах ажилтан (гэр бүлийн гишүүд) хөлсөлж авах санхүүгийн чадвартай байгаа тохиолдолд л үүнийг хянаж болно. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдгээрийн гэр бүлийнхэн ерөнхийдөө эдийн засгийн боломж бололцоогүй байдаг учир засгийн газрын зүгээс төлбөрийг нь төлөх шаардлагатай байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд болон оюун ухааны бэрхшээлтэй иргэд энэхүү үйлчилгээг хянахад дэмжлэг хэрэгтэй болдог.

Хувийн туслалцааны үүрэг

Хувийн туслалцаа гэдэг нь зөвхөн ойр дотно найз нөхдийн хувиар хүмүүст туслахыг хэлж байгаа ойлголт биш юм. Энэ нь өөр өөр нөхцөл байдалд төрөл бүрийн зорилгоор хүмүүст дэмжлэг үзүүлэхийг хэлж болно. Үүнд: гэрт (эцэг эх, асран хамгаалагчийн үүргээр), сургууль дээр, ажлын байранд, олон нийтийн дунд (аялах, дэлгүүр хэсэх, банкаар үйлчлүүлэх гэх мэт). Албан ба албан бус аль ч хэлбэрийн хувийн туслалцаа үзүүлсэнээс үл хамааран эцсийн дүнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үзүүлж буй туслалцаа тоон болон чанарын хувьд гэр бүлийн болон хамт олны амьдралд чухал ач холбогдолтойгоор, бүрэн дүүрэн оролцох боломжоор хангасан байх нь чухал.

Хувийн туслалцаан дахь “Хувийн” хэмээх ойлголтын тухай

Хувийн туслалцаан дахь хувийн хэмээх ойлголт нь хүн бүр өөр хоорондоо ялгаатай, хүн бүрийн хэрэгцээ шаардлага давтагдашгүй өөр гэдэг утгыг илэрхийлж

Хувийн туслалцаан дахь “Хувийн” хэмээх ойлголтын тухай

Хувийн туслалцаан дахь хувийн хэмээх ойлголт нь хүн бүр өөр хоорондоо ялгаатай, хүн бүрийн хэрэгцээ шаардлага давтагдашгүй өөр гэдэг утгыг илэрхийлж байна. Хувийн туслалцаа нь тухайн хувь хүний хэрэгцээнд нийцэх шийдлийг олох арга зам юм. Хэрэгцээ шаардлага нь хувь хүний нөхцөл байдал, нийгмийн үүрэг болон эрүүл мэндийн байдлаас болж өөрчлөгддөг учир өөр өөр түвшний туслалцаа (туслалцаа шаардлагагүй, хэсэгчилсэн туслалцаа, бүрэн туслалцаа) янз бүрийн зорилгоор өөр цаг хугацаанд хэрэгтэй болдог. Туслалцааг зөв тэнцвэртэй сонгох нь хувь хүн бүрт тустай байдаг.

Хяналт

Хувийн туслалцааг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст чиглэсэн, эсвэл тэдний төлөө ямар нэг зүйлийг хийж, тэд идэвхгүй хүлээн авагч болон хувирч байгаа мэт хардаг байсан. Энэ ойлголт одоо хүлээн зөвшөөрөгдөхгүй болсон. Харин хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрийнхөө амьдралын хэв загварыг хянах эрх чөлөөтэй байх ёстой учир тэд өөрийн хувийн туслалцааны хэрэгцээний талаарх шийдвэрийг гаргахад гол үүрэг гүйцэтгэгч байх ёстой. /Жишээ 5-ыг харна уу/

Дэмжлэгийн сонголтууд

Албан бус туслалцаа

Дэлхий даяар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүргэдэг туслалцааны хамгийн түгээмэл хэлбэр нь албан бус туслалцаа юм. Гэр бүлийн гишүүд, найз нөхөд, хөршүүд болон сайн дурынхан энэхүү туслалцааг хүргэдэг.

Албан туслалцаа

Хувийн туслалцааг албан хэлбэрээр хүргэж бас болно. Хөгжингүй орнуудад маш олон төрлийн албан туслалцаа байдаг бөгөөд хөгжиж буй оронд ч албан туслалцааны төрөл өсч байна. Эдгээр үйлчилгээг төрийн байгууллага, төрийн бус байгууллага, мөн хувийн байгууллага хүргэж болно. Төсвийн төвлөрөлийг хэдий чинээ сааруулж чадна, тусламжийн үйлчилгээний санхүүжилтыг төдий чинээ орон нутгийн байгууллагуудаас, тухайлбал нийгмийн халамжийн яамаас авч болно. Хөгжлийн бэрхшээлийн тэтгэвэр, асран хамгаалагчийн тэтгэмж гэх мэт тэтгэмжээр хувийн туслалцааг санхүүжүүлэх боломжтой байж болно.

Тулгарч буй бэрхшээлүүд

Хөгжиж буй орнуудын хязгаарлагдмал сонголтууд

Хөгжингүй болон хөгжиж буй орнуудад хувийн туслалцаа олон төрлийн бэрхшээлүүдтэй тулгардаг. Хөгжиж буй орнуудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хувийн туслалцааг үзүүлэхэд ХОТСЗ хөтөлбөр нь дараах бэрхшээлүүдтэй тулгарч болно. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүл болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд хувийн туслалцаа болон түүний шаардлагын талаар маш бага ойлголттой байх;
- Хөтөлбөрийн зүгээс хувийн туслагч нарт дэмжлэг туслалцаа болон сургалтыг хомс зохион байгуулдаг;
- Хувийн туслалцааг дэмжих нийгмийн хамгааллын бодлого байхгүй байх, тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэтгэмж, тэтгэвэр (цөөн хэдэн хөгжиж буй оронд);
- Цөөн хэдэн үндэстэн хувийн туслалцааны тодорхойлолт, стандарт болон хянах шаардлагатай процедурыг зөвшөөрдөг.

Хямралын нөхцөл байдал

Тусламжийн тогтолцоо байхгүй бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хямралын нөхцөл байдалд орно. Зарим тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүсэл сонирхлыг үл харгалзан асрамжийн газар руу илгээдэг. Хөгжиж буй орнуудад хувийн туслалцааг ихэвчлэн гэр бүлийн гишүүд нь үзүүлдэг ч гэсэн тусламж үгүй болох олон шалтгаан байдаг. Тухайлбал гэр бүлийн гишүүн нь нас барахад гэр бүл дотроо зөрчил үүсэх юмуу санхүүгийн асуудал үүсч болно. Зарим нөхцөлд гэр бүлийн гишүүд ямар нэгэн сургалт, дэмжлэггүйгээр хувийн туслалцааг үзүүлснээс ачаалал ихэсч, стресстэж, ядардаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үзүүлдэг албан бус туслалцааны хувьд ихэнх гэр бүл гол цөм нь байдаг учраас үйлчилгээг гэр бүлд нь үзүүлэх нь чухал байдаг.

Эмзэг байдал ба хүчирхийлэх эрсдэл

Амьдралынх нь аль нэг хэсэгт тусламж дэмжлэг хэрэгтэй байгаа хүмүүс дэмжлэг хэрэггүй хүмүүсээс илүү эмзэг байдаг. Ялангуяа хувийн туслагч нь өөрөө хүчирхийлэгч нэгэн байвал бүр ч их хэцүү байдаг (Харилцаа, гэрлэлт, гэр бүл бүлгийг харна уу).

Санал болгож буй үйл ажиллагаанууд

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудтай хамтарч ажилла

Олон тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хувийн туслалцаа нь түүний хэрэгцээтэй нийцэж байх ёстойг ухуулж ойлгуулахад хэцүү байдаг. Гэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хамтарч ажилласнаар өөрчлөлтийг хийхэд илүү хялбар байдаг. ХОТСЗ хөтөлбөр нь хувийн туслалцааны сонголтуудыг бий болгоход Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагын үүргийг хүлээн зөвшөөрч дараах байдлаар хамтарч ажиллах нь чухал:

- Хувийн туслалцааны нийтээрээ зөвшөөрсөн стандартыг боловсруулах, дэмжих;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хувийн туслалцааны сонголтуудын талаарх мэдээлэл хангалттай эсэхийг баталгаажуулах;
- Үйлчилгээнүүд байхгүй газарт хувийн туслалцааны сонголтуудыг бий болгох;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тохиромжтой хувийн туслалцааны үйлчилгээнүүдийг бий болгох, мөн хянахад нь дэмжлэг үзүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэр дундаа хүнд хэлбэрийн болон хавсарсан бэрхшээлтэй иргэдийг Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага болон өөрөө өөртөө туслах бүлэгтэй холбож өгөх.

Жишээ 6 Монгол

Монгол улсад одоогоор бие даан амьдрах эрхийг хуулиар баталгаажуулсан хэдий ч хувийн туслахын үйлчилгээ хэрэгжиж эхлээгүй бөгөөд нийгэмд үүний талаарх ойлголт мэдлэг хангалтгүй байдаг. Монгол Улсад бие даан амьдрах эрхийг бий болгох зорилгоор хэсэг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нэгдэн 2010 онд “Түгээмэл Хөгжил Төв” бие даан амьдрах төвийг үүсгэн байгуулсан. Тус төв байгуулагдсан цагаасаа эхлэн хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрах үйлчилгээний хэрэгцээ шаардлагыг таниулахад чиглэсэн нөлөөллийн ажил хийх, мөн хувийн туслах болон ижил бэрхшээлтэй хүмүүс зөвлөгөө өгөх (peer counselling) зэрэг үйлчилгээний загвар төсөл хэрэгжүүлэн ажиллаж иржээ. Тэдний зорьж хийж буй ажлын үр дүн эхнээсээ харагдаж байгаа бөгөөд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай хуулийн 32-р зүйлд бие даан амьдрах эрхийг баталгаажуулж, амьдралд хэрэгжүүлэхэд холбогдох дүрэм журам боловсруулагдах шатандаа явж байна. Үүний зэрэгцээ нэг зорилго чиглэлийн дор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өөрсдийн үүсгэл санаачлага оролцоон дээр үндэслэсэн бие даан амьдрах төвүүд бүс нутгуудад байгуулагдаж, улсын хэмжээнд нийт 7 төв ажиллаж байна. Өнөөдөр “Түгээмэл Хөгжил” бие даан амьдрах төв 10 ажилтантай, 140 гаруй гишүүд дэмжигчидтэй бөгөөд дийлэнх гишүүд нь өдөр тутмын үйлдэлд хувийн туслах үйлчилгээ авах шаардлагатай хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эзэлдэг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст өөрийнхөө хувийн төлөвлөгөөгөө боловсруулахад нь тусал

Хувийн туслалцаа нь нийгэм, соёлын хувьд тохиромжтой байх, мөн нас хүйсний хэрэгцээнд тохируулсан хандах нь чухал юм. ХОТСЗ хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст дараах байдлаар тусалж болно. Үүнд:

- Юуг хийхэд туслалцаа хэрэгтэй байгааг болон тэр нь ямар байх бол гэж таамаглал дэвшүүлэлгүйгээр олж илрүүл;
- Орон нутагт байгаа өөр төрлийн хувийн туслалцаануудыг үзэж судал. Өөр төрлийн туслалцааг туршиж үзэх нь аль нь хамгийн сайн тохирч байгааг олж мэдэх сайн арга болно;
- Юун дээр туслалцаа шаардлагатай байдаг, хэзээ хэрэгтэй байдаг, мөн хэрхэн хийх талаар хувийн туслагчтайгаа ярилц;
- Хувийн туслалцааг сайн дурын идэвхтэн эсвэл албан ёсны цалинтай ажилтнаар хүргүүлж байгаагаас үл хамааран гэрээ байгуул;
- Хувийн туслалцаа тогтмол давтамжтайгаар хэрэгтэй байгаа эсэхийг сайн шалгаж, эрүүл мэндийн байдал, өдөр тутмын үйл ажиллагаа болон хүрээлэн буй орчинд нь ямар нэг өөрчлөлт гарч байгаа талаар лавлаж төлөвлөгөөндөө өөрчлөлт оруул.



Жишээ 7 Филиппин

Хувийн туслалцааг төлөвлөх нь

Филиппиний Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үндэсний байгууллага нь Боловсролын газар болон эцэг эхчүүдийн холбоотой хамтарч олон салбарыг хамарсан хөтөлбөрийг боловсруулсан. Уг хөтөлбөрийн гол үүрэг нь эцэг эх болон багш нарт хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сургуульд хамруулахад хувийн туслалцаа үзүүлэх талаар сургалт зохион байгуулах юм. Уг хөтөлбөр нь орон нутагт 13.000 гаруй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж, хүүхэд бүрт тохирсон туслах төлөвлөгөө хэрэгтэй талаарх сургалтыг эцэг эх, багш болон сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд зориулж зохион байгуулдаг. Энэхүү хөтөлбөр нь дэмжлэг хэрэгтэй хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг үе тэнгийнхэнтэй нь хамт сургуульд амжилттай суралцуулсан.

Сургалтын боломжуудыг дэмж

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хувийн туслалцааны хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, түүнийг удирдах чадвар, мөн өөртөө итгэлтэй байдал олж авахад нь сургалт хэрэгтэй байж болно. Мөн хувийн туслагчид нь үүрэг хариуцлагаа гүйцэтгэх чадвараа хөгжүүлэхэд нь туслах сургалтанд суух хэрэгтэй байж болно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс чанартай сайн хувийн туслалцааны үйлчилгээ авахын тулд өөрсдийн хэрэгцээ шаардлага, хүлээж буй зүйлээ илэрхийлдэг чадвартай байх ёстой. ХОТСЗ хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг дараах байдлаар дэмжиж болно. Үүнд:

- Харилцааны болон өөртөө итгэлтэй байх чадварыг хөгжүүлэхэд шаардлагатай сургалтанд хамруулах /Эрх мэдэлжүүлэх бүрэлдэхүүн: Адвокаси ба харилцаа хэсгийг харна уу/
- Хувийн туслалцааны талаарх мэдээллээр хангах
- Хувийн туслалцааны шаардлагыг тодорхойлох, төлөвлөх, удирдах хамгийн сайн аргуудыг сургах
- Гэр бүл, ажлын газар, сургууль болон хамт олны хүрээнд хувийн туслалцааны хэрэгцээгээ хэрхэн зөв тодорхойлохыг сургах

Сургалтыг Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага, орон нутгийн захиргааны байгууллага, сургалтын байгууллага, төрийн бус байгууллага, ХОТСЗ хөтөлбөр болон бусад туршлагатай хувийн туслагч нар зохион байгуулж болно. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд, өөрөө өөртөө туслах бүлгүүд нь хувийн туслалцааны менежментийн талаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст сургалт, мэдээлэл, дэмжлэг үзүүлэх хамгийн сайн эх сурвалж болдог. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд болон өөрөө өөртөө туслах бүлэг байхгүй бол ХОТСЗ хөтөлбөрийн зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийг ижил нөхцөлд байгаа бусад хүмүүстэй нь холбож өгөх үүргийг хүлээж болно.

Хувийн туслагч нарын хувьд

Хувийн туслагч нарын хувьд өөрийнхөө хүлээж буй үүрэг харицлагадаа туршлагатай, өөртөө итгэлтэй байх нь чухал байдаг. Ихэнх тохиолдолд албан бусаар туслалцаа үзүүлж байгаа хувийн туслагч нар хийж буй ажлынхаа чиглэлээр ямар нэг сургалтанд хамрагдаагүй байдаг. Хувийн туслагч нарыг сургалтанд хамруулах нь дараах байдлаар чухал нөлөөтэй. Үүнд:

- Тэдний үүрэг маш чухлыг ойлгох;
- Тэдний хүрч болох хил хязгаарын талаарх ойлголтыг бий болгох;
- Тусалж буй хүнээ сайн сонсож, хэрэгцээнд нь хариу үзүүлэх;
- Хүссэн зүйлийг хийж гүйцэтгэхэд шаардлагатай чадвараа хөгжүүлэх;
- Давхар ажил үүрэг хүлээж байгаа тохиолдолд ажил, цаг хугацаагаа зохицуулах.

Хувийн туслагчаа сургахад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тусламж хэрэгтэй байж болох бөгөөд ХОТСЗ хөтөлбөр, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд болон өөрөө өөртөө туслах бүлгүүд нь энэ нөхцөл байдалд хамгийн сайн эх сурвалж болдог. Мөн бусад төрлийн сургалтын хөтөлбөрүүд тухайн оршин буй газарт байж болох бөгөөд түүнийг судлах шаардлагатай.



Гэр бүлийн гишүүд хувийн туслагч болох үед тэднийг дэмж

Хувийн туслалцаа үзүүлдэг гэр бүлийн гишүүд өөрсдийн бусад үүрэг хариуцлагын хажуугаар энэхүү үүргийг гүйцэтгэдэг. Энэ нь тэднийг өөртөө маш бага цаг зарцуулахад хүргэдэг. Ихэнхдээ гэр бүлийн гишүүд өөрсдөдөө туслалцаа авах талаар бодоогүй байдаг. ХОТСЗ хөтөлбөр нь гэр бүлийн гишүүдэд дараах дэмжлэгийг үзүүлнэ. Үүнд:

- Яаралтай үед үзүүлэх туслалцаа эсвэл туслах ажлаас түр чөлөөлөх сонголтуудыг бий болгох;
- Өөрөө өөртөө туслах бүлэг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд, эцэг эх болон гэр бүлийн байгууллагуудаар дамжуулан тэднийг ижил түвшинд байгаа гэр бүлийнхэнтэй холбох;
- Тэднийг сонсож, ярилцаж, хамтарч ажилласнаар хувийн туслагчийн үүргийг илүү сайн зохицуулах шийдлийг олж болно;
- Гэр бүлийнхнийг сургалтанд хамруулснаар тэд асуудлыг давж гарах стратегийг сурч чадна;
- Хувийн туслагчийн үүргийг гүйцэтгэдэг гэр бүлийн залуу гишүүд сургуульд суралцаж, чөлөөт цагаа өнгөрүүлэх цаг гаргаж байгаа эсэхийг баталгаажуулах.

Хямралын нөхцөл байдалд бэлтгэлтэй байж даван туул

Дэмжлэг, туслалцааны тогтолцоо байхгүй болсон ч гэсэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээ шаардлагыг хангах асуудал үргэлжлэх ёстой. ХОТСЗ хөтөлбөр тэдгээр хүмүүсийг хүнд хэцүү байдлыг даван гарахад бэлэн байлгах зорилгоор бусад гол хүмүүстэй хамтарч урьдчилсан төлөвлөгөө гаргах нь чухал. Хямралын нөхцөл байдлыг даван туулахад хамт олон дэмжин тусалж, уян хатан сонголтуудыг бий болгож байдаг. Нийтээрээ гаргасан шийдвэр нь урт, богино хугацааны алинд нь ч хамгийн тохиромжтой, үр дүнтэй байдаг. ХОТСЗ хөтөлбөрийн менежерүүд нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд

болон орон нутгийн захиргаатай хямралыг даван туулах стратегийг урьдчилан хэлэлцэж зөвшилцөх нь чухал. Хямралын нөхцөл байдал үүсэхээс өмнө хийж болох боломжит сонголтууд нь:

- Танай орон нутагт яаралтай үед дуудах туслах баг байдаг уу? Үүнд орон нутгийн захиргааны байгууллагын нийгмийн ажилтан, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагаас бэлтгэгдсэн төлөөлөгч, хуулийн мэргэжилтэн, ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнаас бүрдсэн баг байж болно.
- Танай орон нутагт түр зуур ашиглах байр байдаг уу? Тэнд сэргээн засах эсвэл тайвшруулах үйлчилгээ үзүүлэх зэрэг сонголтууд байж болох юм.
- Танай орон нутагт бэлгийн болон гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд охидуудыг дэмжих, байрлуулах аюулгүй байр, газар байдаг уу? Шаардлагатай тохиолдолд ийм байрыг хөгжлийн бэрхшээлтэй охид эмэгтэйчүүдэд хүртээмжтэй болгож засаж, тохируулах хэрэгтэй.
- Хямралын нөхцөлд байгаа гэр бүлд тусалдаг нийгмийн ажилтнууд хөгжлийн бэрхшээлийн талаар сургалтанд хамрагддаг уу? Хэрэв үгүй бол Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд болон ХОТСЗ хөтөлбөр энэхүү сургалтыг зохион байгуулж чадах уу?
- Урт хугацаанд шийдэх шийдлийг олтол гэр бүлийн гишүүд түр зуурт туслалцаа дэмжлэгийг үзүүлж байж болох уу?
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага болон ХОТСЗ хөтөлбөр нь хямралын нөхцөлд байгаа бусад гэр бүлд туслалцаа үзүүлэх хүсэлтэй өөр бусад гэр бүлийг олж илрүүлэх боломжтой юу?
- Өөрөө өөртөө туслах бүлэг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийн аль алинд нь олдоцтой байна уу?

Хямралын нөхцөлд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлд гаднаас чиглүүлэгчийн туслалцаа хэрэгтэй болж болно. ХОТСЗ хөтөлбөр нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд, өөрөө өөртөө туслах бүлгүүд болон нийгмийн халамжийн хөтөлбөрүүдтэй хамтарч энэ үүргийг шууд болон шууд бусаар хүлээж болно. Хэрэв тухайн хүн эрсдэлтэй нөхцөлд байгаа тохиолдолд нааштай шийдэл олдохгүй бол хямралт нөхцөл байдлыг багасгаж, түүний амьдралын өөр хэв маягийг олох нь чухал.

Асрамжийн газар очихоос зайлсхийхийг дэмж

Хувийн туслалцаа их шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг асрамжийн газарт илгээдэг уламжлалтай байсан. Хэдийгээр энэ уламжлал өөрчлөгдөж байгаа боловч зарим улс оронд одоог хүртэл асрамжийн газрууд байсаар байгаа бөгөөд зарим нэг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд энэ нь цорын ганц сонголт болдог. ХОТСЗ хөтөлбөр болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд нь асрамжийн газар болон бусад холбогдох төрийн байгууллагуудтай хамтарч цаашдаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан хамгийн зөв тохирох ирээдүйн сонголтыг судлах нь чухал.

Улс орнууд асрамжийн байгууллагуудыг дараах хэлбэрт амжилттайгаар шилжүүлсэн байна. Үүнд:

- Мэргэжлийн сургалт, хөгжлийн төв;
- Сэргээн засах төв;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь хэрэгцээтэй үедээ тусламж аван бие даан амьдрах боломжтой хараат бус орон сууц, байшин;
- Хувийн туслалцаа үзүүлдэг гэр бүлийн гишүүд нь түр амсхийж завсарлага авах хооронд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн богино хугацаагаар байрладаг амрах байр;
- Зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бус эмзэг бүлгийн юмуу хүчирхийлэлд өртсөн бүх хүмүүс байрладаг яаралтай тусламжийн өрөө.

Харилцаа холбоо, гэрлэлт, гэр бүл

Танилцуулга

Харилцаа холбоо, гэрлэлт, гэр бүл нь аль ч хамт олны амин чухал асуудал байдаг. Дэлхий нийтээрээ гэр бүл нь дэмжлэг туслалцаа, аюулгүй байдлын маш чухал эх сурвалж нь хэмээн үздэг. Төрөхөөс эхлээд хөгширтөл амьдралын ямар ч үе шатанд гэр бүлийн гишүүд бие биедээ анхаарал тавьж, өсч хөгжихөд нь дэмжин тусалж таатай аюулгүй орчныг бүрдүүлж байдаг.

Гэр бүлүүд нь өөр хоорондоо ялгарах онцлогтой байдаг бөгөөд үүнд соёл, шашин, уламжлал нөлөөлдөг. Гэр бүлийг цөм, өнөр өтгөн, өрх толгойлсон, хүүхэдгүй, өргөмөл хүүхэдтэй гэр бүл гэх мэт ангилдаг. Бид энэхүү ялгааг сайтар ойлгож хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэр бүл болох эрхийг нь хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцийн 23-р зүйлд “Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусдын нэгэн адил гэрлэх, гэр бүл болох, гэр бүлтэй байх, эцэг эх байх, хамаатан садан байх зэрэг асуудлуудад ялгаварлан гадуурхахын эсрэг тохирох, үр дүнтэй арга хэмжээг авна” гэж заасан байдаг.

Энэ элемент нь хэрэв хөгжлийн бэрхшээлтэй хүн хүсвэл гэрлэх, харилцаа холбоо тогтоох, эцэг эх болох явдлыг нь дэмжихийн чухлыг онцлон харуулж байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүн тогтоосон харилцаа холбоо, гэр бүлийнхээ хүрээнд хүчирхийлэлд өртөж байвал түүнийг илрүүлж, уг асуудалд анхаарлаа хандуулахын чухлыг харуулна.



Жишээ 8 Малауи

Эх болохыг нь дэмжиж урамшуулах нь

Би одоо 40 настай өөрийнхөө төлөө хийж болох бүхнийг хийж чадсанаараа бахархдаг. Би эгч нарыгаа хүнтэй гэрлэж хүүхэдтэй болж байгааг нь хараад би ч гэсэн өөрийн гэсэн хүүхэдтэй болно гэж мөрөөддөг байлаа. Эгч нар маань хүүхдүүдээ өдөр тутмын ажилд маань туслуулахаар явуулдаг байсан боловч хүүхдүүд нь үлдэж надтай цуг хонодоггүй байлаа. Хэдийгээр гэртээ ажиллаж ганцаараа биеэ даан амьдардаг байсан боловч яг л жаахан хүүхэд шиг байлаа. Шөнө болохоор ярих, ус авчирч өгөх, хоолоо хувааж идэх хүнгүй маш их ганцаарддаг байлаа. Үнэхээр аймшигтай.

Тэгээд 25 настай байхдаа би жирэмсэн боллоо. Энэ мэдээ миний эгч нагац, авга нарыг минь гайхшрууллаа, учир нь энэ бол тэдний зүгээс надаас хүлээж байсан ганц зүйл байсан юм.... Тэд надад “хөгжлийн бэрхшээлгүй эмэгтэй хүртэл төрөх явцдаа нас барах тохиолдол гардаг гэтэл чи ямар билээ” чи хүүхдээ төрүүлж чадахгүй гэж намайг айлгаж байсан. Мөн хамаатан садан нь түүнийг жирэмсэн болгосон эрэгтэйг цагдаад барьж өгнө гэж сүрдүүлжээ. Би тэдэнд “тэр эрэгтэй садан төрөлтэй маань танилцаж надтай дотносох үйл явцыг зөв хийгээгүй гэдгээ хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд намайг эхнэрээ болгохыг зөвшөөрсөн” гэж хэлсэн.

Манай эгч, нагац нар миний хүүхдийг үр хөндөж авахуулахаар намайг эмнэлэг рүү авч явахаар ярилцсан байсан. Гэхдээ би сэтгэл зүйн хувьд хүүхдээ авахуулалгүйгээр төрүүлнэ гэж шийдчихсэн байсан. Би өөрөө жирэмслэлтийн талаар зөвлөгөө авахаар эмч дээр очсон. Эмч намайг эрүүл хүүхэд төрүүлэх боломжтой гэж хэлсэн.

Би хөөрхөн охинтой болсон бөгөөд энэ явдал манай гэр бүлийг эвлэрүүлж баяр хөөртэй болгосон юм. Хэдэн жилийн дараа би нөгөө хүнтэйгээ гэрлэсэн бөгөөд дахин хөөрхөн хүүтэй болсон юм. Одоо охин маань 18-тай, хүү маань 14-тэй бөгөөд хүүхдүүд маань над шиг ээжтэйдээ гуныж гутаж байгаагүй.

Энэ бол хөгжлийн бэрхшээлтэй хэрнээ хэрхэн эцэг эх болсон талаар миний хувийн туршлага юм. Хамгийн чухал хэрэгцээ бол дэмжлэг юм. Би сэтгэл зүйгээ маш өөдрөг байлгасан. Би өөрийнхөө туршлагаас харахад хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй жирэмсэн болно гэдэг бол хөгжлийн бэрхшээлгүй хүмүүсийн хувьд боломжгүй үзэгдэл байдаг. Хүн бүрийн мэдэж байх ёстой зүйл бол хүүхдээ гаргах уу үгүй юу гэдэг талаарх зөв шийдвэрийг л гаргах явдал байдаг.

Малауигийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зөвлөл
Жулиан Прискилиа Мабангве



Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байр суурийг гэр бүл, хамт олон бүрэн дүүрэн ойлгох явдал юм.

ХОТСЗ-ын хөтөлбөрийн үүрэг

ХОТСЗ хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг гэр бүл, хамт олныхоо гишүүдтэй харилцаа тогтооход дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хүсч буй үр дүн

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс харилцаа холбоо тогтоож, гэр бүл зохиож, үр хүүхэдтэй болох чадвартай гэдгийг хамт олны гишүүд ойлгож хүлээн зөвшөөрнө.
- Хөгжлийн бэрхшээлтэй эцэг эх болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эцэг эхийг өөрсдийнхөө эцэг, эхийн үүргийг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэх хөтөлбөр, үйлчилгээнд хамруулна.
- Гэр бүлийнхэн нь хөгжлийн бэрхшээлтэй гишүүнээ нийгэмшиж, гэр бүлээс гадуурх харилцаа үүсгэхэд нь урамшуулж дэмжинэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хүчирхийллээс хамгаалж, энэ асуудлыг шийдэхэд бүх гол хүмүүс хамтарч ажиллана.
- Хязгаарлагдмал нийгмийн харилцаатай хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамт олон нь сайн дэмждэг болно.

Гол ойлголтууд

Харилцаа

Хувийн харилцаа тогтоох нь хүн бүрийн хувь хүний хөгжилд маш чухал асуудал байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэлтгүй бүх хүний хувьд найз нөхөд, гэр бүл, хамтрагчтайгаа тогтоосон харилцаагаа сэргээх, үргэлжлүүлэх, харилцаандаа сэтгэл хангалуун байх гэдэг нь маш чухал байдаг.

Гэр бүл

Гэр бүлд хамаарагдахуй

Гэр бүл гэдэг үг нь өөр өөр хүмүүст өөр өөр утгыг илэрхийлдэг. Гэр бүл нь янз бүрийн хэлбэр хэмжээтэй байдаг боловч тэдний хамгийн түгээмэл зүйл нь бие биедээ хамаарагдах ойлголт юм. Гэр бүл нь сурч хөгжих орчныг бүрдүүлдэг бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, эмзэг бүлгийнхэн болон хүүдүүдэд аюулгүй орчинг бүрдүүлж өгдөг.

Хөгжлийн бэрхшээлд үзүүлэх гэр бүлийн хариу үйлдэл

Гэр бүл бүр хөгжлийн бэрхшээлд үзүүлэх хариу үйлдэл нь янз бүр байдаг. Нэг гэр бүл хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд төрөхөд хүлээн зөвшөөрөхөд их хэцүү байдаг бол нөгөө гэр бүл нь айж цаашид юу болох талаар мэдээлэл олж авахыг хичээдэг. Магадгүй нөгөө хэсэг гэр бүл нь хүүхдээ төрснийг баярлан тэмдэглэдэг.

Гэр бүл нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулахад өөрчлөлтийг гаргагч, үр нөлөөтэй ухуулагч байж чаддаг. Тэд хөгжлийн бэрхшээлтэй гишүүдээ хүлээн зөвшөөрүүлэхэд эерэг нөлөө үзүүлж, мөн хамт олны хандлагад ч эерэгээр нөлөөлж чаддаг.

Бэлгийн амьдрал

Бэлгийн амьдрал нь эрүүл сайн сайхан байхын нэг чухал хэсэг юм. Олон газарт энэ асуудлыг эмзэг, хориотой зүйл мэтээр хүлээн авдаг бөгөөд ялангуяа энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбоотой тохиолдолд боломжгүй хэмээн ойлгодог. Жишээ нь: хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бэлгийн амьдралд орж үр хүүхэд төрүүлэх боломжгүй. Энэ нь зөвхөн нийгмийн дунд байгаа ойлголт бус эмнэлэгийн мэргэжилтнүүд, зарим тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдөө ч ингэж боддог байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь бусдын адил бэлгийн хэрэгцээ шаардлагатай гэдгийг бид ойлгох хэрэгтэй. Харамсалтай нь эдгээр хэрэгцээ шаардлагууд нь үгүйсгэгддэг /Нэмэлт товхимол: ХОТСЗ ба ДОХ/ХДХВ харна уу/.

Жишээ 9 Уганда

Эндүүрэл

Угандагийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Үндэсний холбооны залуу эмэгтэй гишүүд “Биднийг эрүүл мэндийн төв дэр зохиогддог олон нийтийн хөтөлбөрт оролцуулдаггүй.....үнэндээ хүмүүс биднийг хөгжлийн бэрхшээлтэй учраас бэлгийн амьдралын хувьд идэвхгүй гэж үздэг” гэжээ.

Гэрлэлт ба эцэг эх болохуй

Хөгжлийн бэрхшээлтэй хүнээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд төрнө гэсэн бодол ихэнх хүмүүст байдаг. Мөн хүмүүсийг биеэ дааж хүүхдээ асран хамгаалж чадахгүй гэсэн түгээмэл ойлголт байдаг. Хэт туйлширсан зарим тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй ялангуяа оюун ухааны бэрхшээлтэй охид эмэгтэйчүүдийн үрийн сувгийг мэдлэггүйгээс нь эсвэл тэдний зөвшөөрлийг авалгүйгээр боодог. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцийн 23-р зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн гэрлэлт, эцэг эх болох эрхтэй холбоотойгоор: гэрлэх, гэр бүл зохиох, хэдэн хүүхэдтэй байхаа чөлөөтэй шийдэж тэднийхээ төлөө хариуцлага хүлээж, насандаа тохирсон мэдээлэл авах, гэр бүл төлөвлөх, нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол эзэмших, мөн үр тогтоох чадвараа авч үлдэх зэрэг эрхээ өөрсдөө шийдэх эрхтэй гэж заажээ.

Жишээ 10

Гэр бүлтэй болохыг хүсэхүй

Миний мөрөөдөл бол гэрлээд үр хүүхэдтэй болох явдал юм. Гэвч миний эцэг, эх намайг гэр бүлээ тэжээх чадваргүй болохоор гэрлэх боломжгүй гэж хэлсэн. Би үүнд итгээгүй.

Хүчирхийлэл

Хүчирхийлэл нь гэр бүл, сургууль, ажил, хамт олон гэх мэт нийгмийн аль ч шатанд тохиолддог. Олон төрлийн хүмүүс хариуцлага хүлээдэг. Ялангуяа буруу ойлголт, уламжлалт сөрөг хандлага, итгэл үнэмшил, үл тоох зэрэг хүчирхийлэлд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хүч тэнцвэргүй байдаг; тэд биеийн, бэлгийн, сэтгэл зүйн болон сэтгэл хөдлөлийн хүчирхийлэл, хайхрахгүй байх, мөн санхүүгийн дарамтанд орох эрсдэл өндөр байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд албадан үрийн сувгийг боох болон бэлгийн хүчирхийлэлд өртдөг.

Санал болгож буй үйл ажиллагаанууд

Буруу ойлголт, мухар сүжиг, ялгаварлан гадуурхалтанд анхаарлаа хандуул

Ихэнх хамт олонд хөгжлийн бэрхшээлийн талаарх сөрөг хандлага, ойлголт, практик байсаар байна. ХОТСЗ хөтөлбөр асуудлыг дараах байдлаар давахад тус болно:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн загвар жишээ болсон, эерэг дүр төрхийг хөхиүлэн дэмжихийн тулд олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдтэй хамтарч ажиллах;
- Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээнүүд - гэр бүл төлөвлөлт зэрэг үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй болгохын тулд эрүүл мэндийн мэргэжилтнүүдийг хөгжлийн бэрхшээлийн талаар ойлголт нэмэгдүүлэх сургалтанд хамруулах;
- Буруу ойлголт болон ялгаварлан гадуурхалтыг давах, мэдрэмтгий асуудлуудаар хамт олонтой ярилцлага хийх боломжийг нээх, хөгжлийн бэрхшээлийн талаар ойлголт бий болгохын тулд орон нутгийн манлайлагч нар, шашны тэргүүнтэй хамтарч ажиллах.

Жишээ 11 Либериа

Бэлгийн болон хөгжлийн бэрхшээлийн талаарх асуудлуудыг судлах

Бэлгийн болон хөгжлийн бэрхшээлтэй холбогдсон асуудлуудыг хэзээ ч авч үзэж байгаагүйг ХОТСЗ хөтөлбөр хэрэгжүүлдэг Либериагийн орон нутгийн төрийн бус байгууллага олж мэдсэн. Тус хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй ярилцаж энэ асуудлын талаар судалж эхэлсэн. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд хэдийгээр айдаг ч гэсэн бэлгийн амьдралд орох боломжтой гэдгээ илэрхийлэх нь чухал гэдэг нь ярилцлагаас харагдсан. Тэд бэлгийн амьдрал маш чухал бөгөөд эх болж нийгэмд чухал үүрэг гүйцэтгэнэ гэж боддог байна. Зарим тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйг бэрхшээлгүй эрэгтэй хүчирхийлсэн байдаг. Хөгжлийн бэрхшээлийн талаарх сөрөг хандлагаас болж олон нийтийн дунд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйтэй харилцах нь эрчүүдийг бусад хүмүүс буруу ойлгоход хүргэдэг гэж боддог.

Эцэг, эхчүүдэд дэмжлэг үзүүл

Эцэг, эхчүүдэд зөв шийдвэр гаргахад мэдээлэл, дэмжлэг хэрэгтэй. ХОТСЗ хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй эцэг, эх болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эцэг, эхтэй аль алиныг нь анхааралдаа авах ёстой. Дараах байдлаар дэмжлэг үзүүлэх авах боломжтой:

- Гэр бүлийн дэмжлэг, эх хүүхдийн эрүүл мэнд, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд гэх мэт дэмжлэгийг эцэг, эхэд үзүүлдэг орон нутгийн үйлчилгээг олж мэдэх;
- Хөтөлбөр, үйлчилгээнүүдийг тогтмол хэвийн болгохын тулд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага болон хөгжлийн бэрхшээлтэй эцэг, эх болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эцэг, эхийг хамруулсан бусад байгууллагуудтай хамтарч нөлөөллийн ажил хийх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, өсвөр насныхныг хөтөлбөр, үйлчилгээг хүртэхэд нь туслах зуучлах системийг дэмжин хөгжүүлэх;
- ХОТСЗ хөтөлбөрийн сүлжээгээр дамжуулан бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаарх үнэн зөв мэдээллийг өгөхөд үйлчилгээ үзүүлэгчтэй хамтран ажиллах.



Бие даахыг дэмжих зорилгоор гэр бүлтэй ажилла

Заримдаа гэр бүлүүд хөгжлийн бэрхшээлтэй гишүүнээ хэтэрхий хамгаалж гэртээ байлгаж, хамт олны аливаа ажилд оролцуулж нийгэмшүүлэхгүй байснаар тэдний бусадтай харилцаж, авьяас чадвараа хөгжүүлэх боломжуудыг хязгаарлаж байдаг. ХОТСЗ хөтөлбөр гэр бүлтэй дараах байдлаар ажиллаж болно:

- Хөгжлийн бэрхшээлтэй гишүүнийх нь талаар болон тэдний хамт олны дунд эзлэх байр суурийн талаар мэдээлэл олгож, дэмжлэг үзүүлэх;

- Хэт их хамгаалснаас үүсэх сөрөг үр дагаварыг гэр бүлд нь ойлгуулж туслах;
- Хамт олны дунд байгаа сөрөг хандлагыг өөрчлөхөд гэр бүлийн гишүүд нөлөөллийн ажил хийж болохыг ойлгуулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг өөрийнхөө хэрэгцээ, хүслийнхээ талаар бусадтай харилцаж, өөрөө өөрийгөө өмгөөлөхөд нь туслах.

Хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд тусла

Ямар ч хэлбэрийн хүчирхийлэл нь ХОТСЗ хөтөлбөрийн ажилтанд хэцүү асуудал байдаг. ХОТСЗ хөтөлбөр төрөл бүрийн орчин (гэр, сургууль, ажлын газар, хамт олон гэх мэт)-д хэрэгждэг учир хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хүчирхийллээс хамгаалах нийгмийн хүчтэй сүлжээг бий болгох боломжтой байдаг (Энэ товхимолын Шүүх хэсгийг үзнэ үү). ХОТСЗ хөтөлбөр нь:

- ХОТСЗ хөтөлбөрийн ажилтанг хүчирхийллийн шинж тэмдгийг таньж мэддэг чадвартай болгох, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хаанаас хуулийн зөвлөгөө авах талаар мэдлэг олгож, чадавхийг бэхжүүлж чадна;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамгаалахад авах арга хэмжээ болон хөгжлийн бэрхшээл ба хүчирхийллийн талаарх хамт олны ойлголтыг нэмэгдүүлж чадна;
- Холбогдох гол хүмүүс (гэр бүл, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага, эрүүл мэндийн болон боловсролын ажилтан, хууль, шүүхийн мэргэжилтэн, орон нутгийн манлайлагч болон орон нутгийн удирдах албаныхан)-тэй холбоо тогтоож, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хүчирхийллээс хамгаалах тэдний үүргийн талаар ярилцаж чадна;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хүчирхийллийн талаарх мэдүүлгийг итгэлтэйгээр өгөх процедурыг гол хүмүүстэй хамтарч боловсруулж чадна;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хүчирхийлэлд өртсөн тохиолдолд хэрхэн мэдүүлэг өгөх талаар зөвлөгөө өгч чадна;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг өөртөө итгэлтэйгээр хамт олны ажиллагаанд оролцуулж, хүчирхийллээс хамгаалахад туслах нийгмийн сүлжээнүүдийг хөгжүүлж чадна;
- Хүчирхийлэлд өртөж байсан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй ярилцаж, тэднийг эрүүл мэндийн үйлчилгээ авахад нь болон шийдвэр гаргаж, тодорхой арга хэмжээ авахад нь туслаж чадна;
- ХОТСЗ хөтөлбөрийн болон сайн дурын ажилтнууд хүчирхийллийн гэмт хэргийн түүхгүй байгаа эсэхийг шалгадаг хөтөлбөрийн болон байгууллагын бодлоготой байхыг баталгаажуулж чадна.



Нийгмийн сүлжээний хязгаарлалттай хүмүүсийг дэмж

Зарим хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэр бүлгүй эсвэл тэдний гэр бүл нь тэдэнд шаардлагатай тусламж, дэмжлэг үзүүлж чаддаггүй байж болно. Тиймээс зарим хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс асрамжийн газар, дотуур байр, сүм хийд, нийтийн байранд амьдардаг эсвэл орон гэргүй байдаг. Энэ нөхцөлд ХОТСЗ хөтөлбөр дараах үйл ажиллагаагаар дэмжиж чадна:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага, Өөрөө өөртөө туслах бүлэг гэх мэт тохирох байгууллагуудтай нь холбож өгөх;
- Асрамжийн газартай хамтарч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь хамт олны амьдралд оролцох боломжоор хангагдаж байгаа эсэхийг баталгаажуулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг өөрийн хүсч буй амьдралаараа амьдрахад нь дэмжих;
- Орон гэргүй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тохирох байр сууц олоход нь, боломжтой бол өөрийнх нь өмнө амьдарч байсан газраа ахин амьдрахад нь туслах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс амьдарч байгаа газраа ямар нэгэн хүчирхийллийн шинж тэмдэггүй амьдарч байгаа эсэхийг анхаарах.



Соёл ба урлаг

Танилцуулга

“Соёл” гэдэг үг маш олон утгатай. Гэхдээ энэ удаад хэсэг бүлэг хүмүүсийн амьдралын арга гэсэн утгаар илэрхийлэгдсэн. Тиймээс соёлд хувцас, хоол, хүнс, хэл, итгэл үнэмшил, үнэ цэнэ, шашин, ёс заншил, практик гэх мэт маш олон зүйлийг агуулж байна. Урлаг нь соёлтой маш ойрхон холбоотой байдаг, тухайлбал уран зураг, хөгжим, бүжиг, уран зохиол, кино, фото зураг гэх мэт.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг соёл, урлагийн арга хэмжээнд оролцуулах, эсвэл оролцоход нь туслах шаардлагагүй гэж зарим хүмүүс үздэг. Бүтээх, өөрийгөө илэрхийлэх гэх мэт оюуны хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж болохуйц эдгээр зүйлсийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст чухал биш гэж ихэнхдээ үздэг. Тухайлбал, ихэнх гэр бүлүүд ХБ хүнийг эрүүл мэндийн үйлчилгээ авах нь хэрэгтэй гэж боддог боловч соёлын арга хэмжээнд авч очих, оролцуулах нь тийм ч чухал биш гэж боддог.

Соёлын амьдралд оролцох нь хувь хүн, гэр бүл, хамт олныг нэг бүхэл болгодог хүний эрх юм (дараах жишээг үзнэ үү).

Жишээ 12

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхий тухай конвенци, 30-р зүйл:
Соёлын амьдралд оролцох, чөлөөт цаг, амралтаа өнгөрүүлэх, спортоор хичээллэх

- Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусдын нэгэн адил тэгш байх үндсэн дээр соёлын амьдралд оролцох эрхийг хүлээн зөвшөөрөх бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дараах эрхийг хангах зохистой бүхий л арга хэмжээг авна: а) Соёлын бүтээлийг хүртээмжтэй хэлбэрээр хүртэх; б) Телевизийн хөтөлбөр, кино, театр болон соёлын бусад арга хэмжээг хүртээмжтэй хэлбэрээр хүртэх; в) Театр, музей, кино театр, номын сан, аялал жуулчлалын үйлчилгээ зэрэг соёлын үзвэр, үйлчилгээ эрхэлдэг газрууд болон түүнчлэн хөшөө дурсгал болон үндэсний соёлын ач холбогдол бүхий газруудад ч нэвтрэх боломжтой байх.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зөвхөн өөрийн сайн сайхны төдийгүй нийгмийн баялагт хувь оруулах үүднээс уран бүтээлийн, урлагийн болон оюуны чадавхиа ашиглах болон хөгжүүлэх боломжийг тэдэнд бий болгох зохистой бүхий л арга хэмжээг Оролцогч улсууд авна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс урлагийн бүтээлийг хүртэхэд оюуны өмчийн эрхийг хамгаалсан хууль тогтоомж нь үндэслэлгүй, алагчлах шинжтэй саад тотгорыг үүсгэхгүй байх явдлыг хангах үүднээс Оролцогч улсууд бүхий л зохистой арга хэмжээг олон улсын эрх зүйн дагуу авна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусдын нэгэн адил тэгш байх үндсэн дээр өөрсдийн соёлын тусгай болон хэл ярианы онцлог байдал тухайлбал, дохионы хэл болон сонсголгүй хүмүүсийн соёлыг хүлээн зөвшөөрүүлэх эрхтэй.

Жишээ 13 Колумби

Хүүхдэд зориулсан сэргээн засалтыг сонирхолтой, хөгжилтэй болгоход урлагийг ашигласан нь

FANDIC (Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг нийгэмшүүлэхэд найз нь байх) нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажилладаг Колумбийн Букараманга дахь сан юм. Тэдний зорилго нь ХОТСЗ хөтөлбөрөөр дамжуулж хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг нийгэмшүүлэхэд оршино. Тэдний хэрэгжүүлдэг төслүүдийн нэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг бүжиглүүлэх төсөл юм. Зорилго нь:

- Хүүхдийн бие махбод, урлагийн чадварыг нь хөгжүүлэх
- Багаар ажиллаж, нийгэмшүүлэх
- Хувь хүн, хамт олон, байгууллагын болон засгийн газрын түвшинд хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт нэмэгдүүлэх.

5-21 насны хөдөлгөөний болон оюун ухааны бэрхшээлтэй 12 хүүхэд бүжгийн бүлэгт ордог. Тэдний ах, эгч нар нь гэр бүлийг оролцуулж, нийгэмшүүлэхийг дэмжсэн. Долоо хоногт нэг удаа мэргэжлийн бүжигчин ирж хүүхдүүдэд бүжиг заадаг. Харин бусад хугацаанд нь сайн дурын идэвхтнүүд хүүхдүүдтэй ажилладаг. Хүүхдүүдэд энгийн бүжиг зааж эхлээд, дараа нь нэлээн ярвигтай бүжигнүүдийг заасан. Бүжгээр дамжуулж хүүхдүүд сунгалтын дасгал хийж, нийгмйн бусад үйл ажиллагаанд оролцдог. Хүүхдүүдийг хайрлаж, энхрийлж, сэтгэлийг нь хөдөлгөж, өөрийнхөө чадвартаа итгэлтэй болгож хөгжүүлж байна.

Бүжгээр дамжуулж маш сайн стратеги олсноо FANDIC хуваалцаж байна. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан сэргээн засалтыг хөгжилтэй, сонирхолтой болгож болгоно
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн үйлдлийг сайжруулна
- Харилцах, нийгэмшүүлэхэд боломж олгоно
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, гэр бүл болон бусад хүмүүсийн хоорондын харилцааг сайжруулна
- Хандлагын саад бэрхшээлийг



Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдийн гэр бүл болон хамт олны соёл, урлагийн амьдралд оролцож хувь нэмрээ оруулах.

ХОТСЗ-ын хөтөлбөрийн үүрэг

ХОТСЗ хөтөлбөрийн үүрэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг соёл, урлагийн үйл ажиллагаанд оролцуулахад холбогдох гол хүмүүстэй хамтран ажиллахад оршино.

Хүсч буй үр дүн

- Хөгжлийн бэрхшээлийг ялгаварлан гадуурхах, буруу ойлгох асуудалд соёл, урлагаар дамжуулан анхаарал хандуулна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд соёл, урлагийн арга хэмжээнд өргөнөөр оролцоно.
- Байгууллага, бүлгүүд соёл, урлагийн хөтөлбөр, үйл ажиллагаандаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг оролцуулна.
- Соёл, урлагийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон арга хэмжээ болж байгаа газрууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй болсон байна.
- Оюун санааны болон шашны манлайлагчид болон бүлгүүд нь үйл ажиллагаандаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулдаг болсон байна.

Гол ойлголтууд

Оролцооны төрөл

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг гэр бүл, хамт олны соёл, урлагийн амьдралд оролцуулах олон арга зам бий. Тэд найруулах, удирдах, бичих, гүйцэтгэх зэргээр шууд идэвхтэй оролцож эсвэл жүжиг, кино үзэх, үндэсний хувцас өмсөх зэрэг идэвхгүй хэлбэрээр оролцож болно.

Оролцооны ашиг тус

Соёл, урлагийн үйл ажиллагаа нь зөвхөн таашаал аваад зогсохгүй хувь хүнд тэд хэн бэ гэдгийг заадаг. Оролцох үйл явц нь хувь хүнийг эрх мэдэлжүүлж, өөрийн дуу хоолойгоо сонсож, бас бусдад сонсгоход тусалж болох юм. Мөн эрүүл мэндийн ашиг дэм байгаа. Хөгжлийн бэрхшээлтэй зарим хүмүүсийн хувьд соёл, урлагт тулгуурласан үйл ажиллагаанууд нь тэднийг бусдын нэгэн адил өөрийгөө бүрэн дүүрэн төлөөлөх утгатай ч байж болох юм.

Соёл, урлагийн үйл ажиллагаа нь гишүүдээ сайн сайхан байлгахад онцгой хувь нэмэр оруулдаг. Эдгээр үйл ажиллагаа нь хамт олны харилцааг бэхжүүлж, чадавхжуулж, хамт олны хөгжлийг дэмжиж, мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сэргээн засах үйл явцыг идэвхжүүлнэ. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг соёл, урлагийн үйл ажиллагаанд оролцуулах нь хөгжлийн бэрхшээлийн талаарх хамт олны хандлага эерэгээр өөрчлөгдөх сайн үзүүлэлт болдог.

Соёл, урлагийг нийгмийг өөрчлөх арга хэрэгсэл болгох нь

Хүмүүсийг хүнд хэцүү, харгис ширүүн, ялгаварлан гадуурхах байдалтай хүчирхийллийн бус аргаар сөрөхөд урлагийг хэрэглэсээр ирсэн. Анхаарлаас гадуур байгаа хүмүүс тэрхүү мэдрэг, эмзэг байгаа сэдвийг илэрхийлэх хамгийн аюулгүй найдвартай өргөн чөлөөнүүдийн нэг гэж үздэг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс урлагаар дамжуулан хөгжлийн бэрхшээлийн асуудлыг ил гаргаж ирдэг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд урлаг нь дэлхий ертөнцийг илүү хамруулахад дүрслэх хэрэгсэл болж болно.

Жишээ 14 Бангладеш

Харанхуйд харах нь

Харанхуйд харах нь гэдэг уран зургийн үзэсгэлэн нь 2003 оны 12-р сард Бангладешийн Дака хотын Друпад галлерейд амжилттай явагдсан. Тус үзэсгэлэнг Хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн тусламж, сэргээн засалтын төв (SARPV) болон Дэлхийн эрүүл мэндийн сүлжээ хамтарч нөлөөлөлд харилцах нь төслийнхөө нэг хэсэг болгон зохион байгуулсан юм. Харааны бэрхшээлтэй 25 хүн, хөдөлгөөний бэрхшээлтэй 5 хүнтэй ажлын хэсэг, мөн олон улсын зураачид тус үзэсгэлэнг бүтээхэд оролцсон. Энэ нь зөвхөн уран зургийн үзэсгэлэн яармаг болоод зогсохгүй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өдөр тутмын амьдралд тулгардаг бэрхшээлийг гаргаж ирсэн. Галлерей тэр чигтээ харанхуйд болсон ба Дака хотын амьдралыг дуу чимээ болон хүртэхүй ашиглан хүн, тэрэг, цэцэрлэг, явган хүний зам болон дэлгүүрүүдийг бүтээсэн. Ирсэн үзэгчид хараагүй хүн шиг дуу чимээ, хүртэхүйгээр мэдэрч явсан. Үзэсгэлэн үзсэн сэтгэгдэл, үзэл бодлоо графитан ханан дээр бичсэн. Үзэсгэлэн үзсэний дараах эерэг үр дүн нь ирсэн үзэгчдийн дунд хөгжлийн бэрхшээлийг мэдрүүлж, төсөлд оролцогчид болон ирсэн үзэгчид хамтарч ажиллан, харааны бэрхшээлтэй иргэд ижил мөнгөн тэмдэгтийг ялгахад хүнд байдгийг бодолцон үзэж мөнгөн тэмдэгтийг ялгаатай болгохоо Бангладеш Банк амлажээ.

Хөгжлийн бэрхшээл ба урлаг

Олон оронд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд өөртөө итгэл дүүрэн байх, хөгжлийн бэрхшээлтэй болгож байгаа саад бэрхшээлийн талаар ойлголтыг нэмэгдүүлэх, хамт олон дотроо эв нэгдлийг бий болгоход урлаг тус дэм үзүүлдэг. Театр, бүжиг, уран зохиол болон харж мэдрэх буюу кино урлаг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүний эрхээ эдлэх нэг хэлбэр юм.. Дуут дохио, тэргэнцэртэй бүжиг

болон бусад шинэлэг зүйлүүд нь хувь хүн, бүлэг, хамт олноос шинээр гарч ирсэн хэлбэрүүд байдаг. Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүсийн хувьд бичлэг, үзүүлбэр болон харж мэдрэх буюу кино урлаг нь мэдрэмжээ илэрхийлэх, туршлагаа хуваалцахад нь маш хүчтэй хэрэгсэл нь болдог.

Үлгэр дууриалал

Хөгжлийн бэрхшээлтэй ихэнх уран бүтээлчид үндэсний болон олон улсад танигдаж, хөгжлийн бэрхшээлийн талаар их зүйлийг ойлгуулж, бусдыг зоригжуулж үлгэр дууриалал нь болсон байдаг. Олон уран бүтээлчид хамт олны хамруулсан хөгжилд өөрийн ур чадвар, энергийг зориулдаг.

Жишээ 15

Энх тайваны элчүүд ойлголтыг түгээхэд туслаж байна

2009 оны 12 дугаар сарын 3 (олон улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өдөр)-нд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст онцгой анхаарал хандуулж алдарт дуучин, дуу зохиогч Стиви Вондерыг НҮБ-ын элч болгон зарласан билээ. Энх тайваны элч нар нь урлаг, эрдэм, уран зохиол, спорт, энтертэймент чиглэлээр өөрийн авьяасаараа олонд танигдсан, НҮБ-ын туйлын зорилго, үйл ажиллагааны талаар ойлголт нэмэгдүүлэхэд тусалж байдаг хүмүүс байдаг. Олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон хүмүүнлэгийн ажлаар олон нийтэд ил гарснаар НҮБ дэлхийн өнцөг булан бүрийн хүмүүсийн амьдралд хэрхэн тусалж байгаа талаарх ойлголтыг нэмэгдүүлдэг юм.

Санал болгож буй үйл ажиллагаанууд

Соёл, урлагаар нийгмийн өөрчлөлтийг хөхүүлэн дэмж

Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх нөлөөллийн ажил нь тухайн орон нутгийн соёл, урлагийн мэдээллийн хэрэгсэлд суурилбал илүү үр дүнтэй болдог. Тиймээс ХОТСЗ хөтөлбөрүүд нь хөгжлийн бэрхшээлийн талаарх нийгмийн сэтгэлзүйг өөрчлөх эдгээр мэдээллийн хэрэгслийг ашиглах хэрэгтэй. Хөтөлбөр нь:

- Уран бүтээлчидтэй хамтарч жүжиг, хөгжмийн арга хэмжээ зохион байгуулж, хамт олны дунд буй буруу ойлголт, ялгаварлан гадуурхалтыг болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тохиолддог бэрхшээлийг таниулж болно;
- Хошин шог, хүүхэлдэй болон түгээмэл урлагийг ашиглан хориотой сэдвүүдэд анхаарлаа хандуулах замаар судлаж болно;
- Жүжиг, кино, театр зэрэг соёл урлагийн мэдээллийн хэрэгслээр хөгжлийн бэрхшээлийн талаар болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эерэг дүр зургийг бий болгоход болно.

Жишээ 16 Мали

Соёлын сургалтанд хөрөнгө оруулах нь

Амадоу болон Мариам нар олон улсад нэрд гарсан Малигийн хөгжимчид юм. Тэд өөрсдийн авьяас чадвараараа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг тодотгож хэвшмэл ойлголтыг эвдсэн юм. Тэд соёлын сургалтын хөтөлбөрт хөрөнгө оруулж хөгжлийн бэрхшээлтэй залуусыг өөрсдийн хүсэл мөрөөдлөө даган авьяас, ур чадвараа хөгжүүлэх боломж олгосон.



Гэр бүлийн оролцоог дэмж

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй ихэнх гэр бүлүүд буруу ойлголт, ялгаварлан гадуурхалтаас айж соёлын арга хэмжээнд оролцох, тэдгээр газраар явах итгэлээ алдсан байдаг гэдгийг ямагт санаж байх хэрэгтэй. Тэд хурим найр, шашны үйлчилгээ, ресторан болон кино театрт очих үедээ санаа нь зовж, ичиж, таагүй сэтгэгдэлийг мэдэрдэг байж болно. ХОТСЗ хөтөлбөр нь тэдгээр гэр бүлтэй хамтарч, дараах байдлаар дэмжлэг үзүүлж байх нь чухал:

- Гэр бүлийн гишүүдийг сонсож, тэдэнд сэтгэгдлээ илэрхийлэхэд урам өгч, таньж мэдэж, айдсаа давж гарахад дэмжих;
- Ижил зүйлийг даван туулсан бусад гэр бүлүүдтэй холбоотой болгох;
- Орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудтай гэр бүлийг нь холбоо тогтоож, буруу төсөөлөлтэй байгаа гэр бүлүүдийн итгэл найдварыг төрүүлж, хүсэл мөрөөдлийг нэмэгдүүлэх.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг оролцуул

ХОТСЗ хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог дэмжихдээ:

- Соёл, урлагийн ижил сонирхолтой нэгнээ олж болох, мөн олон төрлийн үйл ажиллагаанд оролцож өөртөө итгэх итгэлээ олж авч болох зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудтай болон бүлэгтэй холбож өгөх;
- Боломжтой бол урлаг, уран бүтээлээрээ олонд танигдсан хөгжлийн бэрхшээлтэй уран бүтээлчийг олж, хөтөлбөрийн үйл ажиллагааг боловсруулах болон хэрэгжүүлэхэд тэднийг оролцуулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн урлагийг дэмжих төслийг боловсруулахад гол хүмүүстэй хамтарч ажиллах;
- Үггүй театр, илүү олон үзэгчийг хамарсан урлагийн төрөл гэх мэт шинэ урлагийн хэлбэрийг хөгжүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг дэмжих, туслах;
- Бүжиг, жүжиг, хөгжмийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эмчлэх эмчилгээний нэгэн төрөл болгохыг дэмжих, туслах

Байгууллага, бүлгүүдтэй хамтарч ажилла

ХОТСЗ хөтөлбөр нь байгууллага, бүлгүүдтэй хамтарч соёл, урлагийнх нь хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг оролцуулж, тэдний авьяас чадварыг хөгжүүлж, өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. ХОТСЗ хөтөлбөр нь:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулахад шаардлагатай тохирох хэрэглэгдэхүүнийг баталгаажуулахын тулд гол хүмүүстэй хамтран ажиллах. Тухайлбал барилга байгууламжийг (иргэдийн танхим, мөргөлийн газар, кино театр, жуулчдын очдог газрууд) ХБ-т хүмүүст хүртээмжтэй болгох, эсвэл мэдээлэл, сурталчилгааны материалыг хүртээмжтэй форматаар боловсруулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг соёлын хөтөлбөрүүд хамрагдах хамрагдалтыг нэмэгдүүлэхийн тулд эмэгтэйчүүдийн бүлгүүдтэй нэгдэх;
- Урлагийн боловсролыг аль болох бага насанд нь, сургуульд байхад нь олговол хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд бага наснаасаа соёл, урлагийн үйл ажиллагаанд оролцож, ач холбогдлыг нь ойлгох боломжтой болно;
- Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, тэднийг хамруулахын тулд соёл, урлагийн хөтөлбөрүүдээс төрөл бүрийн сургалт зохиоход хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудыг дэмжих;
- Соёл, урлагийн хөтөлбөрүүдийг удирдах, зохион байгуулахад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сургаж, ажиллуулахыг дэмжих.

Жишээ 17 Палестин

Соёлын хөтөлбөрүүдэд хамруулсан нь

2000 онд Палестиний ХОТСЗ хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг зуны зусланд хамруулах санаачлага гаргасан. Энэ санаачлага тун амжилттай болж хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг зун болгон оролцуулдаг зуршилтай болоод байна. Мөн зуслангийн залуу манлайлагч нар нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг өөр бусад хөтөлбөрүүдэд жилийн турш хамруулдаг болсон. Жишээлбэл, Үнсгэлжин гэдэг алдартай хүүхдийн үлгэрт хөгжлийн бэрхшээлтэй охин гол дүр бүтээсэн. Энэ зөвхөн хэвшмэл сэтгэлгээг эвдсэн хэрэг бус хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг олон нийтэд таниулж хөгжлийн бэрхшээлтэй залуучуудад эерэг үлгэр дууриалал болгосон.

Оюун санааны болон шашны удирдлагууд, бүлгүүдтэй хамтарч ажилла

Оюун санааны болон шашны манлайлагч, удирдагчууд нь нийгмийг өөрчлөхөд хүчтэй нөлөө үзүүлэгчид байдаг ч заримдаа тэд сөрөг хандлага үзлийг ч бий болгож чаддаг. Тиймээс ХОТСЗ хөтөлбөр тухайн орон нутгийн шашны удирдлага, гишүүдтэй хамтарч ажиллан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тэдний үйл ажиллагаанд оролцуулахыг хөхүүлэн дэмжиж ажиллах итгэлийг өгөх хэрэгтэй. ХОТСЗ хөтөлбөр нь:

- Шашны болон оюун санааны үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулахын чухлыг болон хөгжлийн бэрхшээлийн талаар мэдээлөл өгөх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийг ялгаварлан гадуурхахын эсрэг үйл ажиллагаа явуулахад нь манлайлагч, удирдагчийг дэмжих;
- Шашны болон оюун санааны үйлчилгээ, хөтөлбөрт оролцоход хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хувийн тусламж ашиглаж байгаа эсэхийг баталгаажуулах;
- Мэдээллийг хүртээмжтэй болгох талаар манлайлагч, удирдагчдад зөвлөгөө өгч, тусламж үзүүлэх. Жишээлбэл: мөргөл үйлдэх, дуу, сүмийн магтаал дуу, сургаал, номлолыг дохионы хэлээр орчуулах, шашны текстийг том үсгээр, аудио болон Брайлаар хэвлэх;
- Сүм, хийд хөгжлийн бэрхшээлтэй хүн саадгүй орж, гарч байх хүртээмжийг бий болгосон эсэхийг баталгаажуулж манлайлагч, удирдагч нартай ажиллах.



Амралт, чөлөөт цаг, спорт

Танилцуулга

Соёл урлагийн нэгэн адил амралт, чөлөөт цаг, спортын үйл ажиллагаанууд нь хамт олны дунд томоохон үүргийг гүйцэтгэдэг. Эдгээр нь хувь хүний сайн сайхан, эрүүл энх байдлыг сайжруулж, хувь хүнийг эрх мэдэлжүүлэхэд хувь нэмрээ оруулж, олон нийтийг хамруулан хөгжүүлэх, таниулах олон давуу талуудыг агуулж байдаг. Амралт, чөлөөт цаг болон спортын арга хэмжээнүүд нь хувь хүн, жижиг бүлэг, баг болон хамт олныг хамардаг бөгөөд үүнд бүх насныхан, өөр өөр ур чадвартай, авьяастай хүмүүс оролцож болдог. Амралт, чөлөөт цаг, спортын арга хэмжээ нь тухайн оршин байгаа газраас шалтгаалан тухайн нийгмийн систем болон соёлын үнэт зүйлийг харуулдаг тул олон төрөлтэй байна.

Амралт, чөлөөт цаг, спортын үйл ажиллагаанд оролцох нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд гэрээс гарч хамт олны амьдралд оролцох цөөхөн боломжуудын нэг байж болох юм. Эдгээр үйл ажиллагаануудад оролцох эрхийг доорх жишээ илүү тодруулж өгсөн. Соёл, урлагийн үйл ажиллагааны нэгэн адил хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс идэвхтэй (сагсан бөмбөгийн багийн гишүүн), эсвэл идэвхгүй (хөл бөмбөгийн тэмцээний ажиглагч) хэлбэрээр оролцож болно.

Жишээ 18

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхий тухай конвенци, 30-р зүйл, 5-р хэсэг:

Соёлын амьдралд оролцох, чөлөөт цаг, амралтаа өнгөрүүлэх, спортоор хичээллэх

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс амралт, чөлөөт цагаа спортын арга хэмжээнд бусдын нэгэн адил тэгш оролцох боломжийг олгохдоо Оролцогч улсууд нь дараах зохистой арга хэмжээг авна: а) Нийтэд зориулсан спортын арга хэмжээний бүх шатанд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг аль болох бүрэн хэмжээгээр оролцуулах явдлыг дэмжих; б) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тусгайлан зориулагдсан спорт, чөлөөт цагийн арга хэмжээг зохион байгуулах, хөгжүүлэх болон оролцох боломжийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст өөрт нь олгох, үүний тулд бусдын нэгэн адил шаардлагатай сургалт, бэлтгэл, хэрэгслээр хангах; в) Спорт, чөлөөт цагаа өнгөрүүлэх, аялал жуулчлалын байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байх; г) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд тоглох, наадах, амралт чөлөөт цагаа спортын арга хэмжээнд, тухайлбал сургууль дээр зохион байгуулагдаж байгаа ийм төрлийн арга хэмжээнд бусад хүүхдийн нэгэн адил ижил тэгш оролцох боломжоор хангах; д) Чөлөөт цагаа өнгөрүүлэх, аялал жуулчлал, амралт, спортын үйл ажиллагааг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зохион байгуулах боломжтой байх.

Жишээ 14 Морокко

Спортоор дамжуулан нийгэмд оролцуулах, хувь хүний хөгжлийг бий болгох

Handicap International байгууллага “Спортыг нийгэмд оролцуулах, хувь хүний хөгжлийн хэрэгсэл болгох” төслийг 2007 онд Мороккод эхлүүлсэн юм. Handicap International байгууллагын судалгаагаар (2004 он) Морокко улсад 1.5 сая иргэд хөгжлийн бэрхшээлтэй ба энэ хөтөлбөрийн зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг спортоор хичээллэх боломжийг нэмэгдүүлэх болон сэргээн засалт, эрүүл мэндийн тусламж, мөн нийгэмшүүлэхэд тулгарч буй тэгш бус байдалд анхаарлаа хандуулах байв.

Энэ хөтөлбөр 3 салбарт анхаарлаа хандуулсан.

1.Мороккогийн институтуудын чадавхийг бэхжүүлж, сүлжээг бий болгох – хөтөлбөрийн ажилтнууд Мороккогийн Роял Федерэйшн Спортс Холбоотой (спортын мэргэжилтнүүд боловч хөгжлийн бэрхшээлийн талаар хязгаарлагдмал мэдлэгтэй), мөн Мороккогийн 600 гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэнд, боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай стратегийг боловсруулж, олон улсын болон үндэсний түвшинд түншлэл бий болгох зорилгоор хамтран ажилласан. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн спорт клубуудад жижиг төсөл олгож, төсөл бичих, боловсруулах, хөрөнгө босгох, менежментийн чадварыг хөгжүүлэх сургалтанд хамруулсан.

2.Спортын тохирох тоног төхөөрөмжөөр хангах - тэргэнцэр, зориулалтын хувцас, тохируулсан тоног төхөөрөмж. Жишээ нь: хараагүй хүмүүст зориулсан чимээ гаргадаг бөмбөг.

3.Спортын үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд – төрөл бүрийн спортын үйл ажиллагааг зохион байгуулсан. Үүнд: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн олон улсын өдөр, Бүгдээрээ уралдъя зэрэг тэмцээнд 2000 гаруй хөгжлийн бэрхшээлгүй болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс уралдсан. Хөгжлийн бэрхшээлтэй тоглогчидтой өндөр түвшний хөл бөмбөгийн тэмцээнийг Мороккогийн Хаан ивээн тэтгэсэн бөгөөд төгсгөлийн шатны тоглолтыг үндэсний телевизээр шууд дамжуулж 20.000 орчим хүн үзсэн байна.

Хөтөлбөр амжилтанд хүрсэн баримтуудаас дурдвал:

- 1500 гаруй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс спортын клуб болон байнгын спортын үйл ажиллагаанд оролцсон;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөртөө тохирох технологи, тоног төхөөрөмжтэй болж, зөвлөгөө өгөх дасгалжуулагчтай болсон зэрэг чанартай үйлчилгээг хүртэх болсон;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь бүх төрлийн чадвартай хүмүүстэй уулзах, тэдэнтэй харилцах боломжтой болсон.



Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс амралт, чөлөөт цаг, спортын үйл ажиллагаанд бусдын нэгэн адил идэвхтэй оролцож, мөн ажиглагчаар оролцох.

ХОТСЗ-ын хөтөлбөрийн үүрэг

ХОТСЗ хөтөлбөрийн үүрэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг амралт, чөлөөт цаг, спортын үйл ажиллагаануудад оролцох оролцоог нэмэгдүүлж, амралт, чөлөөт цаг болон спортын үйл ажиллагааг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тохирох, хүртээмжтэй болгоход чадавхийг нь бэхжүүлж, байгууллагууд болон хөтөлбөрүүдэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хүсч буй үр дүн

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрийн орон нутагтаа амралт, чөлөөт цаг, спортын хөтөлбөрүүдэд оролцдог болно.
- Орон нутгийн, үндэсний болон олон улсын эрх бүхий хүмүүс, нийгэмлэгүүд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг амралт, чөлөөт цаг, спортын үйл ажиллагаандаа хамруулдаг болно.
- Гэр бүл, багш нар болон хамт олны гишүүд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амралт, чөлөөт цаг, спортын арга хэмжээнд оролцох эрхийг хөхиүлэн дэмжиж таниулна.
- Амралт, чөлөөт цаг, спортын үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй болон бэрхшээлгүй хүмүүсийг хамтад нь хамруулна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс амралт, чөлөөт цаг, спортын уралдаан тэмцээнд оролцох боломжтой болно.
- Амралт, чөлөөт цаг, спортод ашиглагдах тоног төхөөрөмжийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээг хангахуйцаар тохируулна.
- Амралт, чөлөөт цаг, спортын хөтөлбөрүүд болон үйл ажиллагаануудыг шаардлагатай тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тусгайлан зохионо.

Гол ойлголтууд

Тодорхойлолт

Энэ элементэд:

Амралт гэдэг нь бие болон оюун санаагаа сэргээхийн тулд, цагийг илүү сонирхолтой, таатай өнгөрүүлэхийн тулд хүмүүсийн сонгодог бүхий л үйл ажиллагаа юм. Тухайлбал: алхах, усанд сэлэх, бясалгах, ном унших, тоглоом тоглох, бүжиглэх.

Чөлөөт цаг гэдэг нь хүмүүсийн өдөр тутмын хийдэг үйлдлээсээ (ажил, гэрийн ажил гэх мэт) холдож амарч, амьдралаас таашаал авахад зарцуулдаг чөлөөт цаг юм. Чөлөөт цагаараа хүмүүс амралт, спортын үйл ажиллагаанд оролцдог.

Спорт гэдэг нь биеэрээ хийх бүхий л төрлийн үйл ажиллагаа юм. Жишээлбэл: хөл бөмбөг, регби, сагсан бөмбөг болон хөнгөн атлетик.

Хамт олны амралт, чөлөөт цаг, спорт

Хөгжиж буй ихэнх улс орнуудад хүмүүс зөвхөн амь зуухын тулд ажил хийдэг тул чөлөөт цаг гэдэг ойлголтыг хүмүүс төдийлөн сайн ойлгохгүй, тэдний хувьд тийм ч амин чухал зүйл биш байдаг. Үнэндээ, өндөр хөгжилтэй орны хүмүүсийн хийдэг зугаа гаргадаг зүйлс нь хөгжиж буй орны хүмүүсийн хувьд амьдрах арга нь байдаг. Тухайлбал: загас барих, гар урлал гэх мэт.

Ихэнх улс оронд амралт болон спортын үйл ажиллагааны төрлүүд нь нас, хүйс, орон нутгийн нөхцөл байдал (хот, хөдөө) болон нийгэм эдийн засгийн байдлаараа тодорхойлогддог. Тухайлбал, буурай хөгжилтэй орнуудын хүүхдүүд мод, чулуу, дугуй, олс мэтчилэнгийн хаягдсан, үйлдвэрийн зүйлс зэрэг байгалийн материал ашиглан тоглодог. Чөлөөт цаг нь мөн үндэсний бүжиг, үлгэр ярих, шашны баяр ёслол, арга хэмжээ болон аялан тоглолтын үзүүлбэр үзэх зэрэг соёлын үйл ажиллагаанд тулгуурладаг.

Ихэнх хөдөө, орон нутгийн хүмүүст чөлөөт цагаа өнгөрөөдөг спортын стадион, төв зэрэг тусгай газар байдаггүй тул тэд мөргөлийн газар, кафе, гэр болон ил задгай талбайд цуглардаг.

Хөгжиж буй орны хүн ам нь анхдагч хэрэгцээгээ хангадаг, хязгаарлагдмал төсөвтэй байдаг. Тиймээс албан ёсны амралт, спортын үйл ажиллагаа/хөтөлбөр нь ихэнхдээ ивээн тэтгэгчээс хамааралтай байдаг. Гадны санхүүжилтаар тухайн тухай орон нутагт зохиож буй хөтөлбөр/арга хэмжээнүүд нь орон нутгийн нөхцөлд тохирч байгаа эсэхийг анхаарч, зохион байгуулах нь чухал.

Оролцооны ашиг тус

Амралт, спортын үйл ажиллагаанд оролцох нь хувь хүн болон хамт олонд аль алинд нь ашиг тустай:

- **Эрүүл мэндээ дэмжиж, өвчнөөс урьдчилан сэргийлэх** – амралт, спортын үйл ажиллагаа нь эрүүл энх, сайн сайхан байх хамгийн таатай, мөн үр дүнтэй арга юм. Тэд стрессээ тайлж, биеийн галбираа дээшлүүлж, биеийн болон сэтгэцийн эрүүл мэндээ сайжруулж, зүрхний шигдээс зэрэг архаг өвчнөөс урьдчилан сэргийлнэ.
- **Ур чадвараа дээшлүүлэх** – амралт, спортын үйл ажиллагаанд оролцсоноор бие бялдрын болон нийгмийн чадварууд зэрэг олон чадварууд дээшилнэ.
- **Буруу ойлголтыг бууруулж, нийгэмшүүлэх, ойлголт нэмэгдүүлэх** – амралт, спортын үйл ажиллагаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог нэмэгдүүлэх хүчтэй бөгөөд зардал багатай арга юм. Бүх насны, мөн төрөл бүрийн ур чадвартай хүмүүст таашаал авчирдаг бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүч чадал, ур чадварыг бий болгож, хөгжлийн бэрхшээлийн эерэг дүр төрхийг хөхиүлэн дэмжихэд боломж олгодог.
- **Олон улсын энх тайван ба хөгжил** – спорт бол энх тайваныг уриалдаг олон улсын хэл бөгөөд хил хязгаар, соёл, шашныг үл харгалзан хүмүүсийг нэгтгэдэг, энх тайваныг дэмждэг бие биенээ ойлгодог хүчтэй хэрэгсэл юм.
- **Эрх мэдэлжүүлэх** – амралт, спортын арга хэмжээ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өөртөө итгэх итгэлд эерэгээр нөлөөлж, эрх мэдэлжүүлдэг.

Жишээ 20 Эритрея

Дайны ахмад дайчид үлгэр дууриалал болдог

Эритреад хөгжлийн бэрхшээлтэй дайнд оролцсон ахмад дайчид хөл бөмбөгийн багийн менежер болон дасгалжуулагчаар ажиллах сургалтанд сууснаар Асмара нийслэл хотод болсон 2000 гаруй хүүхдүүд оролцсон хүүхдийн хөл бөмбөгийн тэмцээнийг явуулахад гол үүрэг гүйцэтгэжээ. Үүнд оролцсоноор хөгжлийн бэрхшээлтэй ахмад дайчдын өөрийгөө үзэх үзэл нь өөрчлөгдөж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг үнэлэх хүүхдүүдийн үзэлд эерэгээр нөлөөлж, хөгжлийн бэрхшээлтэй бусад хүмүүсийн хувьд эерэг үлгэр дууриалал болж чадсан. Энэ амжилтыг гаргаснаар, спортын клуб сонсголгүй хүүхдүүдэд зориулсан хөл бөмбөгийн сургалт зохион байгуулж хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн спортын үйл ажиллагаанд оролцох анхны алхам тавигдсан юм.

Амралт, спорт нь бусад боломжийг нээдэг

Амралт, спортын үйл ажиллагааны маш олон ашиг тус байгаа бөгөөд боловсрол, амьжиргаа гэх мэт бусад боломжуудыг орлуулж болохгүй гэдгийг санах хэрэгтэй.

Жишээ 21 Афганистан

Дугуйн сургалт

Афганистаны исламын бүгд найрамдах улсад болдог Афканы мөчөө тайруулсан дугуйчдын сэргээн засалт, амралтын хөтөлбөр нь мөчөө тайруулсан хүмүүст дугуй унахыг сургадаг бөгөөд тэдний хөдөлгөөнийг болон бие даасан байдлыг сайжруулж, тээврийн зардлаа хэмнэн ажлаасаа ирж, очих боломж олгосон юм.

Амралт, чөлөөт цаг, спортод оролцох боломжтой болох

Зарим хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст амралт, спортын арга хэмжээнд оролцоход нь тохирох хэрэглэгдэхүүн шаардлагатай болж болно. Маш бага бүтээлч байдал гаргаж, уян хатан байхад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг аливаа үйл ажиллагаанд оролцуулахад шаардагдах тоног төхөөрөмж болон үйл ажиллагааг хамгийн бага зардлаар эсвэл ямар ч зардалгүйгээр тохируулах боломжтой.

Жишээ 22

Спортын үйл ажиллагааг тохируулах

Тоглоомын дүрэм болон оноо тооцох системийг тохируулснаар өөр өөр чадвартай, мөн бүх насны хүмүүс хамт тоглоход ямар ч зардал гарахгүй. Тоног төхөөрөмжийг орон нутгийн материал ашиглаж хийснээр хамт олны оролцоог нэмэгдүүлнэ. Тухайлбал, хатаасан хулууг үртэй нь хамт ашиглаж чимээ гаргадаг бөмбөг хийж болох ба хослож тоглох гэх мэт.

Санал болгож буй үйл ажиллагаанууд

Орон нутагт амралт, чөлөөт цаг, спортын боломжуудыг тодорхойл

Юуны түрүүнд орон нутагт ямар амралт, чөлөөт цаг, спортын боломж байгааг судла. ХОТСЗ хөтөлбөр нь залуучууд болон эмэгтэйчүүдийн бүлэг, хүүхдүүдийн клуб, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зэрэг хамт олны бүлгүүдтэй нягт хамтран ажиллаж, дээрх боломжуудыг судлах ёстой.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог чиглүүл

Хувь хүн, хамт олон өөрсдөө хүссэн, соёлын хувьд тохирох, оролцогчдод таатай байх, мөн хэт зардалтай биш, тогтвортой байх үйл ажиллагаанууд нь амжилттай байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг амралт, спортын арга хэмжээнд оролцоход нь чиглүүлэхийн тулд ХОТСЗ хөтөлбөр дараах зүйлүүдийг санал болгож байна:

- Өөрийн орон нутагт байгаа амралт, спортын боломжуудын талаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг мэдээллээр хангах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг амралт, спортын клубүүдтэй холбох;
- Сургууль дээрх амралт, спортын үйл ажиллагаанд бусад хүүхдүүдтэй нэгэн адил оролцох боломжоор хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хангах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хувийн туслах үйлчилгээг идэвхтэй, идэвхгүй аль ч хэлбэрээр нь сонгох боломж олгох;
- Илүү олон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулахын тулд тэдний амралт, спортыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр эерэгээр харуулах.



Амралт, спортыг ашиглан хамруулах ойлголтыг нэмэгдүүл

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн олон улсын өдөр зэрэг томоохон арга хэмжээнүүдээр амралт, спортын үйл ажиллагааны хэрэгцээний талаар үндэсний болон орон нутгийн түвшинд ойлголт нэмэгдүүлэх үйл ажиллагааг явуулах боломжтой байдаг. Эдгээр арга хэмжээ нь хэвлэл мэдээллийн анхааралд эерэгээр өртөж, өргөн хүрээнд ойлголт нэмэгдүүлэх боломжтой.

Жишээ 23 Пакистан

Хараагүй хүмүүсийн крикетийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээн

Пакистаны хараагүй хүмүүсийн крикетийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнийг үндэсний болон орон нутгийн түвшинд хэвлэл мэдээллийн хэрэгслээр амжилттай дамжуулсны үр дүнд зарим ХОТСЗ хөтөлбөрүүдээс харааны бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан боловсрол, чөлөөт цагийн боломжуудын талаар хүсэлт илгээсэн эцэг эхийн тоо нэмэгджээ.

Бүгдийг хамруулахад хөтөлбөрүүдийг дэмж

Ихэнх амралт, спортын хөтөлбөрүүд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулдаггүй. Тэдгээр хөтөлбөрийг үйл ажиллагаандаа бүх нийтийг хамруулах талаар ХОТСЗ хөтөлбөр анхаарлаа хандуулж болно. ХОТСЗ хөтөлбөр нь:

- Хөтөлбөрүүд соёлын болоод газар зүйн байршлын хувьд онцгой, хот, хөдөө орон нутагт бүх насны, бүх төрлийн чадвартай, бүх хүйсний хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулах талаар үндэсний болон олон улсын байгууллагуудтай зөвлөлдөж чадна;
- Ихэнх үйл ажиллагааг бага зардлаар, эсвэл ямар ч зардал гаргахгүйгээр тохируулах боломжтой байдгийг онцолж, үйл ажиллагаа, тоног төхөөрөмж, өрөө, байр, газрыг хэрхэн аюулгүйгээр тохируулахад санаа өгч, санал гаргаж чадна;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулахад шаардагдах чадварыг хөгжүүлэх сургалтыг хөтөлбөрийн ажилтнуудад зохион байгуулж чадна;
- Амралт, спортын үйл ажиллагааг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй, боломжтой болгохын тулд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын нэгэн адил нөлөөллийн ажил хийж чадна.

Хөгжиж буй оронд мэдээлэл хэрхэн хүргэх, хүмүүсийг хэрхэн хамруулах талаарх мэдээллийг Хөгжилдөх ба хамруулах гарын авлага болон Спорт, амралт, тоглох номноос авч болно.

Жишээ 24

Сургуулийн спортын өдөрлөг

ХОТСЗ хөтөлбөр нь бүх хүүхдүүдийг хамрах боломжийг олгож сургуулийн спортын өдөрлөгийг зохион байгуулахыг дэмжиж болно. Эдгээр спортын өдөрлөг нь сургуулийн насны, хөгжлийн бэрхшээлтэй болон бэрхшээлгүй хүүхдүүд хамт тоглосноор мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлдэг. Арга хэмжээнд оролцсон хүүхдүүд, эцэг эхчүүд, багш нар, сайн дурынхан болон спортын албаны хүмүүст бүгдэд нь эерэг туршлага болно. Тэдний хөгжлийн бэрхшээлд хандах хандлага эерэгээр өөрчлөгдөж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн спортын чадварын талаар ойлголтоо нэмэгдүүлдэг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан хөтөлбөрийг дэмжиж, боловсронгуй болго

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөр хоорондоо уулзах боломж олгож, ижил чадвартай хүмүүс өрсөлдөх боломжийг олгодог. ХОТСЗ хөтөлбөр нь:

- Амралт, спортын хөтөлбөрүүдийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээнд нийцүүлж боловсруулах шийдвэр гаргах явцад сайн үүрэг гүйцэтгэж чадах манлайлагч нар гэдгийг баталгаажуулж чадна;
- Өөрийн амралт, спортын хөтөлбөрийн бүлэг, клуб нээх сонирхолтой хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг дэмжиж, тохирох сургалт болон нөөц бололцоогоор хангаж болно;
- Орон нутгийн амралт, спортын бүлэг клубыг үндэсний болон олон улсын байгууллагуудтай холбож өгөх. Тухайлбал, Оюуны бэрхшээлтэй хүмүүсийн олон улсын спортын холбоо, Олон улсын паралимпийн хороо, Олон улсын тусгай олимп, Сонсголгүй хүмүүсийн олон улсын спортын хороо гэх мэт.

Жишээ 25 Бангладеш

Шатраар холбогдох нь

Бангладеш-д байдаг харааны бэрхшээлтэй хүмүүсийн хамгийн том сүлжээ нь хараагүй хүмүүсийн Брайл шатрын клуб юм. Энэ нь хот, хөдөөгийн клубүүдийн сүлжээ бөгөөд зөвхөн өрсөлдөж, чадвараа дээшлүүлэхээс гадна ижил сонирхолтой хүмүүс бие биетэйгээ холбогдох, тэднийг нийгэмшүүлэх боломж олгодог.

Танилцуулга

Шударга шүүхээр шүүлгэх гэдэг нь шүүх ажиллагаанд хэрэглэдэг тогтолцоо, үйл явц, мэдээлэл, байршилд хүрэх хүмүүсийн чадвар гэсэн өргөн ойлголт юм. Бүх хүн төрөхдөө эрх чөлөөтэй, өөрийн гэсэн үнэ цэнэтэй басхүү хүний эрх нь тэнцүү байдаг. Тиймээс энэхүү үнэ цэнэ, хүний эрх нь зөрчигдсөн тохиолдолд хүн бүр шударга шүүхээр шүүлгэх ёстой.

Хүмүүс гэмт хэргийн хохирогч болсон үед эсвэл эрх нь зөрчигдсөн, буруутан болсон үед өөрийн улсын шүүх тогтолцоог хэрэглэдэг. Шударга шүүхээр шүүлгэх нь хүний эрх бөгөөд бусад бүх эрхээ эдлэх нь чухал. Жишээ нь: хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрлөх эрхийг зөрчсөн эсвэл халдсан тохиолдолд шүүхээр хамгаалуулахын (шийдвэрлүүлэхийн) тулд шүүх тогтолцоог хэрэглэдэг.

Хөгжлийн бэрхшээлтэй болон анхаарлаас гадуур буй эмзэг бүлгийн ихэнх хүмүүс шударга шүүхээр шүүлгэхэд саадтай учирч байдаг. Шударга шүүхээр шүүлгэхгүй бол тэд дуу хоолойгоо хүргэж чадахгүй, эрхээ эдэлж чадахгүй, ялгаварлан гадуурхагдаж, шийдвэр гаргагчдад тайлбарлаж чадахгүйн улмаас тэд бүр ч илүү эмзэг болж, анхааралд өртөхгүй болно.

Энэ элемент нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс шударга шүүхээр шүүлгэхтэй холбоотой ойлголтуудыг өгөх ба хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс шударга шүүхээр шүүлгэх үед тулгардаг саад бэрхшээлийг хэрхэн даван туулах талаар, ХОТСЗ хөтөлбөр хэрхэн туслах талаарх мэдээллийг өгнө. Шүүх ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэрч, тангарагтны шүүгч, хуульч, өмгөөлөгч гэх зэргээр оролцох нь чухал боловч энд хамрагдсан тохиолдол ховор байдаг.

Жишээ 26

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци. 13-р зүйл:
Шударга шүүхээр шүүлгэх

1.Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусадтай адил тэгш байх үндсэн дээр шүүх шатны бүх үйл ажиллагаа, түүний дотор мөрдөн байцаалт болон шүүхийн өмнөх шатны бусад ажиллагаа зэрэг хууль эрх зүйн бүх ажиллагаанд шууд болон шууд бус оролцох үүрэг, тухайлбал гэрчийн хувьд үр нөлөөтэй оролцох явдлыг байцаан шийтгэх ажиллагааны хэм хэмжээ болон насны онцлогт нийцсэн хэрэглэгдэхүүн ашиглах замаар хууль зүйн ажиллагаанд хүртээмжтэй, үр дүнтэй оролцох эрхийг Оролцогч улсууд хангана.

2.Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг шүүх ажиллагаанд үр дүнтэй, хүртээмжтэй оролцох нөхцөлийг хангах үүднээс Оролцогч улсууд хуулийн байгууллагуудад тухайлбал, цагдаа болон хорих ангийн албан хаагчдыг зохих сургалтад хамруулах явдлыг дэмжинэ.

Хамт олны сөрөг хандлагаас болсон Нецанестийн зовлон

Нецанест бол 14 настай охин. Тэр охин жоохон байхдаа хараагүй болсон боловч хэзээ, хэрхэн гэдгийг өөрөө сайн санадаггүй. Хараагүй тэрээр тосгондоо өсөж торнихдоо хэнд ч хэрэггүй гэдгээ мэдэрч өссөн ба “авер” (юу ч хардаггүй, тэнэг гэсэн утгатай) гэж дуудуулдаг байжээ. Тэдний гэрт нь зочин ирэхэд тэр гэр бүлээ ичгүүрт оруулахгүйн тулд хэнд ч харагдалгүй нуугддаг байсан ба тосгонд нь баяр наадам болоход түүнийг оролцуулдаггүй байжээ.

Нэг өдөр түүний нагац эгч нь ирээд ойролцоо тосгонд хараагүй хүүхдийн сургууль байдаг талаар гэр бүлийнхэнд нь хэлжээ. Эцэг эхийнхээ зөвшөөрлөөр Нецанест сургуульд явдаг болсон байна. Тэр сургуульд сурснаар уншиж, бичиж, хоол хийж бас тосгоноосоо өөрөө явж сурсан ба сургуульдаа их дуртай байжээ. Тэр бүр шинэ найзуудтайгаа тусдаа байшин түрээслэдэг болсон байна.

Нэг орой тосгоны нэгэн эр Нецанест дээр ирж унтахыг гуйсан ба оронд нь сургалтын төлбөрийг төлөх мөнгө өгнө гэж амлажээ. Нецанест гэрлэхэд одоохондоо бэлэн болоогүй болохоор сургуулиа дуусгахад анхаарлаа хандуулж байгаа гэж тайлбарлаж саналыг эсэргүүцсэн байна. Хэдэн өдрийн дараа найзууд нь гэртээ байхгүй үед тэр эр буцаж ирээд түүнтэй хамт байх нь амьдралыг нь амар болгоод зогсоохгүй энэ бүгд тэр хоёрын нууц болно гэжээ. Энэ үед Нецанест мөн эсэргүүцсэн байна. Харин тэр эр түүнийг хүчинджээ. Тэр орилж хашгичсан боловч хэн ч туслахаар ирсэнгүй.

Дараа өдөр нь багш нар болсон явдлыг сонсоод цагдаад хандсан байна. Нецанестэд туслахын оронд цагдаа нар болсон явдалд Нецанестийг буруутгаж эхэлжээ. Хамт олны сөрөг хандлага, хөгжлийн бэрхшээлийн талаарх сөрөг итгэл үнэмшлээс үүдээд тосгонд хэд хэдэн хараагүй охид бас хүчиндүүлсэн байсныг тэднийг буруутгаад л өнгөрөв. Энэ мэдээ тосгоноор хурдан тархсан тул хүчиндсэн залуугийн ээж нь Нецанест дээр ирж “Чи өөрийгөө юу хийж байна гэж бод хийчээд одоо миний хүүгийн нэр хүндийг шившиг болгохыг хичээж байна...” хэмээн Нецанестэд уурлаж, доромжилсон байна.

Энэ мэдээ Нецанестийн эцэг эхэд хүрэхэд тэд юу хийхээ мэдсэнгүй. Нэг талаар тэд Нецанестийн аюулгүй байдалд санаа зовж, энэ нөхцөл байдал



Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хүндэтгэж, түүнийг эрхээ бүрэн дүүрэн эдлэж бусдын нэгэн адил шударга шүүхээр шүүлгэхэд оршино.

ХОТСЗ-ын хөтөлбөрийн үүрэг

ХОТСЗ хөтөлбөрийн үүрэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлж, ялгаварлан гадуурхагдаж, нийгэмд хамрагдаж чадахгүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийг шударга шүүхээр шүүлгэхэд туслахад оршино.

Хүсч буй үр дүн

- ХОТСЗ хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хэрэгцээтэй үед нь шударга шүүхээр шүүлгэхэд туслана.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрийнхөө эрхийг болон шударга шүүхээр шүүлгэх явц, боломжуудын талаар мэдлэгтэй болно.
- Хууль сахих салбарын холбогдох гол хүмүүс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээнд чухлаар хандаж, тэднийг ялгаварлан гадуурхахгүй болсон байх.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх зөрчигдсөн үед шударга шүүхээр шүүлгэх албан бус механизмыг боломжтой болгоно.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх зөрчигдсөн үед шударга шүүхээр шүүлгэх эрх албан ёсны механизмыг боломжтой болгоно.

Гол ойлголтууд

Эрх өмчлөгч болон үүрэг хүлээгч

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх болон шударга шүүхээр шүүлгэхэд эрх өмчлөгч болон үүрэг хүлээгчийн хоорондын холбоо хамаарлыг ойлгох хэрэгтэй.

Эрх өмчлөгч – хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эрх өмчлөгч байдаг. Тэд эрх, хариуцлагыг аль алиныг нь хүлээдэг. Эрх өмчлөгчийн хувьд тэд эрүүл мэнд, боловсрол, амьжиргааны боломж, газар, орон сууц болон улс төрийн оролцоо зэрэгт эрх эдэлдэг. Эдгээрийг Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцид тусгасан байдаг.

Үүрэг хүлээгч – эрх эдэлж буй хүн байгаа тохиолдолд эрхийг нь хүндлэх, хамгаалах, эрхийг нь бүрэн хангах үүрэг хүлээгч гэж бас байдаг. Үүрэг хүлээгч нь үндэсний болон орон нутгийн түвшинд төрийн (засгийн газрын) болон төрийн бус (засгийн газрын бус байгууллагууд, шашны манлайлагчид, эцэг эх гэх мэт) хэлбэрт байдаг. Улс орны үүргийг Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцид тусгасан байдаг.

Шударга шүүхээр шүүлгэхэд тулгарах саад бэрхшээл

Шударга шүүхээр шүүлгэхэд хөрөнгө, улс төрийн байдал болон хотод амьдарч байгаа хүмүүст хязгаарлагдмал байдаг. Бага болон дунд орлоготой орны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс илүүтэйгээр шударга шүүхээр шүүлгэхэд саад бэрхшээл тулгарч байдаг. Эдгээр саад бэрхшээл нь:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамгаалахад тохирсон хууль, бодлого байдаггүй – ихэнх улс оронд тэдний эрхийг хамгаалах тусдаа хууль байдаггүй;
- Бие махбодийн саад – хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс цагдаагийн байгууллага, шүүх болон бусад олон нийтийн байгууллагад орж, үйлчлүүлж чаддаггүй;
- Харилцааны саад – хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс шүүхийн салбарын хүмүүстэй үр дүнтэй харилцаж чаддаггүй. Хэрэв сонсголгүй хүмүүст зориулагдсан дохионы хэлмэрч зэрэг тохирох хэрэглэгдэхүүн байхгүй тохиолдолд харилцаж чадахгүй байж болно;
- Мэдээллийн хүртээмжийн дутмаг байдал – хүртээмжтэй мэдээлэлгүйгээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс шүүх тогтолцоо хэрхэн явагддаг, тэдний эрх, үүрэг нь юу гэдэг талаарх мэдэхгүй байж болно;
- Эдийн засгийн саад бэрхшээл – хуульчийн төлбөр, шүүхийн төлбөр зэрэг зардлууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хэт өндөр байж болно;
- Хэрэгцээний талаарх мэдлэг дутмаг байх – цагдаа болон бусад алба хаагчид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн онцлог хэрэгцээг ойлгохгүй байж болно.

Хууль зүйн чадамж

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн 12-р зүйлд: “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь амьдралын бүхий л хүрээнд бусдын нэгэн адил эрх зүйн чадамжтай гэдгийг Оролцогч улсууд хүлээн зөвшөөрнө”. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ихэнх нь хууль зүйн чадамжаа ашиглах боломжгүй байдаг. Тухайлбал, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг үйлдэл хийх чадваргүй гэж ихэнх хүмүүс үздэг учраас шүүхэд нотолгоо өгөх, хуулийн явцад оролцуулдаггүй. Зарим хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрх зүйн чадамжаа ашиглахад дэмжлэг шаардлагатай байдгийг Конвенцид мөн заасан байдаг. Тухайн хүнд тусалснаар сонголт өөрийнх нь гарт байгааг ойлгуулах; мөн аливаа нэг хөгжлийн бэрхшээлтэй хүн нь өөрийн гэсэн түүхтэй, амьдралын зорилго болон сонирхолтой, мөн хууль зүйн чадамжтай гэдгийг бусдад ойлгуулах зэрэг олон хэлбэрээр дэмжлэгтэйгээр шийдвэр гаргаж болно.

Шударга шүүхээр шүүлгэхийг дэмж

Хуулийн хамгаалалт

Үндсэн хууль, хууль, бодлогод хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг баталгаажуулсан байх шаардлагатай. Тэдний эрхийг хууль ёсоор баталгаажуулсан тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх зөрчигдвөл шүүх, удирдах байгууллагууд, цэргийн шүүх, зарим тохиолдолд хүний эрхийн байгууллагуудад шийдвэр гаргаж болно. Шүүхээр хамгаалуулах эрхийн хэлбэр

нь засах ёстой буруугаас шалтгаална. Тухайлбал, оюутныг элсүүлэн суралцуулахыг сургуульд шаардах, засгийн газрын барилга байгууламжуудыг хүртээмжтэй болгох, ажилтны цалинг ялгавартай олгосон ажил олгогчийг торгох, эрүүл мэндийн байгууллагуудад эрүүл мэндийн даатгалын карт олгохыг үүрэг болгох, хүчирхийлэлийг шийтгэх гэх мэт.

Албан бус механизм – хамт олны түвшинд шударга бус, буруу үйлдлүүдийг ихэвчлэн үр дүнтэй шийддэг. Хуулийн хамгаалалтын албан бус механизм нь шашны болон хөгжлийн байгууллагууд, омгийн удирдагч, тосгоны удирдагч, нэгдэл болон нөхөрлөл, хоршоо, боловсролын болон эрүүл мэндийн мэргэжилтэн, нийгмийн ажилтан болон өрхийн тэргүүнээр дамжиж хэрэгжиж болно.

Жишээ 28 Энэтхэг

Албан бус шүүх хувь заяаг өөрчиллөө

Энэтхэгийн Ориссад хамт олонд түшиглэсэн уяман өвчний хөтөлбөр нь ахмадууд болон шашны удирдлагуудтай хамтран уяман өвчнөөс болж гэр, тосгоноосоо хөөгдсөн залуугийн асуудлыг шийджээ. Дахин нэр өгч, дахин төрүүлэх шашны заншлын дараа өнөөх залуу гэртээ шинэ нэртэй болж эргэн ирсэн ба хамт олны амьдралд оролцох болсон юм.

Албан механизм – албан бус хэлбэрээр эрхээ хамгаалуулж чадахгүй тохиолдолд албан буюу шүүхийн оролцоотойгоор хуулийн хамгаалалт ашиглах хэрэгтэй болдог. Энэ нь ихэнхдээ үнэтэй, удаан, мэргэжлийн хуулийн зөвлөгөө шаардлагатай байдаг учир энэ нь эцсийн арга хэмжээ юм. Хөгжиж буй орны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд үнэгүй туслалцаа үзүүлдэг төвүүд эсвэл хүний эрхийн байгууллагууд, төвүүд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эсвэл хөгжлийн байгууллагуудаас л дэмжлэг авах боломжтой байдаг. Хуулиар шийдүүлж байгаа тохиолдолд хувь хүн болон холбогдох бүлгийн хүмүүсийг оролцуулж шийдэх нь чухал байдаг.



Жишээ 29 Филиппин

Хуулийн үнэгүй тусламж үзүүлэн шударга шүүхийг олсон нь

Манилагийн томоохон банк мөнгө тоологч автомат машин худалдан авсан учир мөнгө тоологчоор ажиллаж байсан олон тооны сонсголгүй ажилтнуудын гэрээг дуусгавар болгожээ. Филиппиний хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үндэсний холбоо – (КАМПИ)-ны тусламжтайгаар хуулийн үнэгүй туслалцаа өгөх хуульч нартай холбогджээ. Хэдэн жилийн дараа үндэсний хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ялгаварлан гадуурхалтын эсрэг хуулийн дагуу Филиппиний дээд шүүх гэрээ цуцлах нь хууль бус, ялгаварлан гадуурхсан гэж үзсэн. Шүүхийн шийдвэрээр банк халагдсан ажилтнуудын ажилгүй байсан бүх хугацаан дахь цалинг нөхөн олгож, тэднийг хуучин тушаал дээр нь ажиллуулахаар болсон боловч тэд хуучин ажилдаа буцаж орохын оронд нөхөн олговрын мөнгөөрөө жижиг бизнес эрхлүүлсэн байна.

Хуулийн мэдлэг

Хуулийн мэдлэг бол шударга бустай тэмцэх үндэс нь юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хуулийн дагуух эрхээ мэдэхгүй бол шударга бус тохиолдолд шүүхээр эрхээ хамгаалуулж чадахгүй. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүл эрхээ мэддэг болсон тохиолдолд тэд бусад хүмүүсийн эрх зөрчигдөж байгааг ажиглаж, тэд нарын төлөө ярьж, эрхийг нь хамгаалах чадвартай болно.

Хуулийн туслалцаа

Албан ёсны хуулийн процесстой холбоотой зардал нь өндөр байдаг бөгөөд ихэнхдээ шударга шүүхийг хайж байгаа хүмүүсийн урмыг хугалдаг. Хуулийн туслалцаа нь шударга шүүхийг эхлүүлэх болон мөрдөхөд хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн эмзэг бүлгийн хүмүүст дэмжлэг үзүүлдэг. Тухайлбал, хуулийн туслалцааны хөтөлбөр нь хуулийн асуудалтай хүмүүст зөвлөгөө өгөх, хууль болон эрхээ ойлгоход нь туслах, шүүхэд төлөөлөх зэрэг дэмжлэг туслалцаанд санхүүгийн дэмжлэг үзүүлдэг. Засгийн газар хуулийн туслалцаа үзүүлэх үүрэгтэй боловч энэхүү үүрэг хариуцлагаа биелүүлэхэд хязгаарлагдмал чадавхтай тохиолдолд засгийн газрын бус байгууллагууд энэхүү туслалцааг үзүүлэх эх үүсвэр болдог.

Хамт олны хууль зүйн төвүүд

Хуулийн туслалцааг авахад шаардагдах шаардлаганд нийцэхгүй байгаа, нөөц бололцоо багатай хүмүүст хуулийн үйлчилгээ үзүүлэх нэг арга нь Хамт олны хууль зүйн төвүүд, эсвэл хуулийн сургуулийг ашиглах байдаг. Хамт олны хууль зүйн төв нь ихэвчлэн хуулийн үйлчилгээ үзүүлдэг ашгийн бус, жижиг байгууллагууд байдаг. Эдгээр байгууллагууд чухал эх үүсвэр болдог. Тэд зөвлөгөө өгч, туслаж, зуучилж, шаардлагатай бол шүүхэд төлөөлж, мөн хуулийн талаар мэдээлэл олгох зэрэг үйлчилгээнүүдийг үзүүлдэг. Мөн тэд ойлголт нэмэгдүүлэх, хамт олонд хуулийн боловсрол олгох, бодлого боловсруулах, лоббидох (шударга хуулийн системийг хөгжүүлэхэд нөлөөллийн ажил хийх гэх

мэт) болон хуулийн үйл явц, удирдлагын шинэчлэлийн төлөө ажилладаг. Хамт олны хууль зүйн төвийн гол онцлог нь сайн дурынхныг ашиглан үйлчилгээг үзүүлдэг. Тиймээс “хамт олон” гэдэгт мэдлэг туршлагатай, зарцуулсан цаг хугацаандаа хөлс авдаггүй хуульч, оюутан, дунд мэргэжлийн хуульчид болон бусад хүмүүс ордог. Эдгээр төвүүд нь хувийн хуулийн мэргэжилтэнтэй харилцаа тогтоож болно. Тухайлбал хувийн хуульчид, хуулийн сургуультай харилцаатай байдаг хоршоо, нөхөрлөл зэрэгтэй сайн дураар, төлбөргүй үйлчилгээ үзүүлэх тал дээр зөвшилцөж болно.

Жишээ 30 Эквадор

Хүүхдүүдийг сургуульд буцаж ороход нь туслав

Эквадорын Күйтод амьдардаг бяцхан охины эцэг эх нь түүнийг гудамжинд гуйлга гуйхыг хүчилдэг учраас сургуульд сурч чаддаггүй байжээ. Охины эмээ үүнд их санаа зовдог байв. Энэ асуудлыг гэр бүлийнхээ хүрээнд шийдэж чадаагүй тул, эмээ ХОТСЗ хөтөлбөрт хандаж, ач охиноо асран хамгаалах дээр туслахыг хүссэн байна. Хөтөлбөрийнхөн хуулийн туслалцаа өгдөг нийгэмлэгт хандаж эмээд зөвлөгөө өгч, тусламж үзүүлэхээр болжээ. Одоо эмээ ач охиноо асран хамгаалдаг болсон бөгөөд охин сургуульдаа буцаад сурах болсондоо баяртай байна.

Санал болгож буй үйл ажиллагаанууд

ХОТСЗ хөтөлбөр нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд болон бусад иргэний нийгмийн байгууллагуудтай хамтарч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг шударга шүүхээр шүүлгэхэд нь туслах маш олон төрлийн үйл ажиллагааг зохиож болно.

Орон нутгийн нөхцөл байдлын талаарх ойлголтыг дээшлүүл

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг шударга шүүхээр шүүлгэхэд дэмжлэг үзүүлэхийн тулд ХОТСЗ хөтөлбөр ажиллах гэж байгаа тухайн орон нутгийн нөхцөл байдлыг ойлгох шаардлагатай. Хөтөлбөр:

- Хуулийн мэдлэгийг дээшлүүлэх (ерөнхий болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тусгай хууль) - хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд болон хуулийн туслалцаа үзүүлэх үйлчилгээнүүд нь ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнуудад тухайн хуулийг ойлгоход нь туслах эх үүсвэр нь болж болно;
- Хуулийг хэрхэн сахиулах талаарх ойлголтыг нэмэгдүүлэх – цагдаа гэх мэт орон нутгийн хууль сахиулах ажилтнууд гэмт хэргийг хэрхэн мэдээлэх, хохирогч болон гэрчүүдийг хамгаалах ямар механизм байдаг талаар ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнуудад ойлгуулахад туслаж болно;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг шударга шүүхээр шүүлгэхэд туслах боломжтой нөөцүүдийг тодорхойлох (албан бус, албан). Тухайлбал, орон нутгийн манлайлагчид (орон нутгийн засгийн газар, омог, тосгон болон шашны манлайлагч), багш нар, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд, эрүүл мэндийн мэргэжилтнүүд, нэгдэл, нөхөрлөл, хоршоод, хууль сахиулах болон шүүхийн ажилтнууд, хуулийн туслалцаа үзүүлэх үйлчилгээ болон хамт олны хууль зүйн төвүүд гэх мэт.

Холбогдох гол хүмүүстэй эвсэл, холбоо, сүлжээ байгуул

ХОТСЗ хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд болон өөрөө өөртөө туслах бүлэгтэй хамтарч, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эсрэг шударга бус, хууль бус үйлдлийг эсэргүүцэж өөрчлөлтөд бэлтгэхэд нөлөө үзүүлэх хүмүүстэй сайн харилцаа холбоо тогтоох хэрэгтэй.

Эрхийн талаарх ойлголтыг нэмэгдүүл

ХОТСЗ хөтөлбөрийн хүрээнд хуулийн мэдлэгийг дээшлүүлэх стратегиуд нь:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийг эрхээ мэддэг болоход нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудтай хамтарч ажиллах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх болон энэ эрхээ хэрхэн эдлэх талаар холбогдох мэдээллийг хүртээмжтэй форматаар тараах;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд, хүний эрхийн байгууллагууд болон өөрөө өөртөө туслах бүлгүүдтэй хамтран ойлголт нэмэгдүүлэх үйл ажиллагаанд оролцох;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд болон хүний эрхийн байгууллагуудыг гол гол салбарын болон хамт олны, дүүргийн шийдвэр гаргагч нарт хөгжлийн бэрхшээлийн талаар сургалт зохион байгуулахад нь туслах. Тухайлбал, хууль сахиулах болон шүүхийн алба хаагч нар, хуулийн болон эрүүл мэндийн мэргэжилтнүүд, багш нар, шашны болон бизнесийн удирдагч нар гэх мэт.



Цагдаагийн алба хаагч нар сургалтанд хамрагдав

2016 онд ХОТСЗ “Тэгш Дүүрэн” хөтөлбөр, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үндэсний холбоодууд, Цагдаагийн Ерөнхий Газрын Сургалтын төвтэй хамтран цагдаагийн алба хаагч нарт сургалт зохион байгуулсан. Энэхүү сургалтаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн онцлог байдлын талаар дэлгэрэнгүй ойлголтыг Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд цагдаагийн алба хаагч нарт өгч, тэднийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй зөв харилцах анхны мэдэгдэхүүнтэй болгосон. Мөн цагдаа нарт дохионы хэл зааж өгсөн.

Сургалт зохион байгуулсны үр дүнд ЦЕГ-ын Сургалтын төвийн 1-р давхрын ариун цэврийн өрөөг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй зассан бөгөөд энэхүү ажлыг “Түгээмэл Хөгжил” Бие даан амьдрах төвийн хамт олон олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн.

Мөн энэхүү төв нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран хараагүй хүмүүст зориулсан нохойг Монголдоо сургаж бэлтгэх талаар ярилцаж байна.

Боломжит газар албан бус механизмыг дэмж

Хуулийн албан процесс нь тэр болгон тохиромжтой механизм биш байдаг. Ихэнхдээ албан бус механизм нь үр дүнтэй, илүү хурдан, зардал багатай, хамт олны гишүүдэд илүү хүртээмжтэй байдаг. Шударга шүүхээр шүүлгэх албан бус аргуудыг ХОТСЗ хөтөлбөр дэмжиж болох бөгөөд дараах аргуудыг хэрэглэж болно:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сургуульд элсүүлэн сургах талаар орон нутгийн сургуулиудтай хамтран ажиллах;
- Гэр бүлийн маргааныг шийдвэрлэхэд орон нутгийн болон шашны удирдлагуудад хандах. Жишээ нь: нэг нь эсвэл хоёулаа хөгжлийн бэрхшээлтэй хос гэрлэх эрхийн талаарх маргаан;
- Хөгжлийн бэрхшээлтэй фермерүүд хамт олны бусад нэгдлүүдэд орохыг баталгаажуулахын тулд Фермерүүдийн хоршоодтой хамтран ажиллах;
- Хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгч өөрийн данс, зээлийг зохицуулахад банкттай хамтран ажиллах;
- Орон нутгийн эмч нарт дохионы хэлмэрчийн үйлчилгээ авахад нь туслах. Ингэснээр сонсголын бэрхшээлтэй иргэд эрүүл мэндийн үйлчилгээ авч чадна;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг өвлүүлэх эрхээ эдлэхэд нь тусалж гэр бүлийн тэргүүн, омгийн болон шашны удирдагч нартай хамтран ажиллах.



Жишээ 32 Гана

Хамт олны сүлжээ ашиглан шударга шүүхээр шүүлгэх

Ганад амьдардаг залуугийн ганц охин нь харааны бэрхшээлтэй байжээ. Тэр залуу олон жилийн турш өвдөж, үхэх хүртэл нь охин нь асарчээ. Түүнийг нас барсныг хамаатнууд нь сонсоод залуугийн бүх өмч хөрөнгийг нь авч охиныг гэрээс нь хөөжээ. Охин орон нутгийн хамт олонд туслах сүлжээнээс хуулийн зөвлөгөө авч, аавынхаа тэтгэврийн мөнгө болон бүх өмч хөрөнгө, үл хөдлөх хөрөнгийг ч гэсэн өөрийнх гэдгээ тогтоолгожээ.

Боломжит газар хуулийн дагуу зохиох үйл ажиллагааг дэмж

ХОТСЗ хөтөлбөр дараах зүйлсийг хийх нь чухал:

- Хууль ёсны хамт олны итгэмжлэгдсэн гишүүдтэй эвсэл нэгдэл болж, хүчтэй харилцаа үүсгэ;
- Ялгаварлан гадуурхалтын өөр өөр хэлбэрүүдэд ямар хууль, тогтоомж тохиромжтойг олж тогтоохын тулд хуулийн зөвлөгөө ав. Тухайлбал, орон нутгийн гэрээ, үндэсний хууль тогтоомж, олон улсын конвенци, гэрээ гэх мэт;
- Хуулийн дагуу үйл ажиллагаа зохиохоор шийдсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэний шийдвэрийг хүндэтгэ;
- Цаг хугацаа, зардал, аюулгүй байдал, ялангуяа үр дүнтэй хууль, тогтоомж, хамгаалах механизм байхгүй бол хуулийн дагуу явуулах үйл ажиллагаанаас гарах эрсдлийг тооц;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийнхэн хуулийн процесст хамрагдаж байгаа эсэхийг баталгаажуул, мөн гарах эрсдлийн талаар мэдлэгтэй бай;
- Орон нутгийн ядуу хүмүүст хуулийн асуудлаар анхаарлаа хандуулдаг байгууллагуудтай хамтран ажиллаж, мэдлэгийг дээшлүүл (хамт олны эсвэл хуулийн туслалцаа үзүүлэх төвүүд, хуульчдын холбоо, олон улсын хүний эрх, хөгжлийн байгууллагууд).

Жишээ 14 Непал

Шүүхийн төлөөх амжилттай тэмцэл

Непалын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага нь Брайл ашигладаг хүүхдүүдээс шалгалт авахдаа бусад хараатай хүүхдүүдтэй адилхан хугацаанд авч байгаа нь ялгаварлан гадуурхалт мөн гэж Непалын Дээд Шүүхэд хүүхдийн эрхийн конвенцийн хүрээнд хандсан. Энэ хэрэг амжилттай шийдэгдэж Брайл ашигладаг хүүхдүүд бүх шалгалтаа 30 минут илүү өгдөг болсон.

Ашигласан материал

- Dhunagna BM. The lives of disabled women in Nepal: vulnerability without support . Master's thesis, Asian Institute of Technology, Thailand, 2003.
- Convention on the Rights of Persons with Disabilities . United Nations, 2006 (www.un.org/disabilities/convention/conventionfull.shtml, accessed 16 June 2010).
- World report on disability . Geneva, World Health Organization, 2010 (in press).
- Mabangwe JP. Disability to become a parent and enjoy the benefit of parenthood in the community. Community based rehabilitation, Africa network (www.african.org/MA%20DISABILITY%20AND%20PARENTHOOD.php, accessed 17 June 2010).
- Limaye S. Sexuality and women with sensory disabilities. In: Hans A, Patri A, eds. Women, disability and identity . London, Sage Publications, 2003.
- The right to health (Fact Sheet No. 31). Geneva, Office of the United Nations High Commissioner for Human Rights , 2008 (www.ohchr.org/Documents/Publications/Factsheet31.pdf, accessed 16 June 2010).
- Giving voice to the voiceless. A communicating for advocacy learning publication . Cambodia Health Education Media Services (CHEMS), Cambodia, Healthlink Worldwide, Health Action Information Network (HAIn), the Philippines, Social Assistance and Rehabilitation for the Physically Vulnerable (SARPV), Bangladesh, 2007 (www.healthlink.org.uk/PDFs/cfalearningpublication.pdf, accessed 17 June 2010).
- Singer-songwriter Stevie Wonder designated UN Messenger of Peace . UN News centre , 2009 (www.un.org/apps/news/story.asp?NewsID=33118&Cr=disable&Cr1=, accessed 17 June 2010).
- From the field: sport for development and peace in action . Sport for Development and Peace International Working Group , 2007 (www.righttoplay.com/International/news-and-media/Documents/Policy%20Reports%20docs/From_the_Field_Full_Doc_Web.pdf, accessed 16 June 2010).
- Kidd, B. A new social movement: Sport for development and peace. Sport in Society , 2008, 11:370–380.
- Fun inclusive: sports and games as means of rehabilitation, interaction and integration for children and young people with disabilities. Handicap International, Gesellschaft für Technische Zusammenarbeit GmbH (gtz), Medico International, 2008 (www.sportanddev.org/learnmore/?uNewsID=12, accessed 16 June 2010).
- Sport, recreation and play . UNICEF , 2004 (www.unicef.org/publications/index_23560.html, accessed 16 June 2010).
- Lord JE, Guernsey KN, Balfe JM, Karr VL, Flowers N (eds). Human rights. Yes! Action and advocacy on the human rights of persons with disabilities . University of Minnesota Human Rights Resource Center, 2007 (www1.umn.edu/humanrts/edumat/hreduseries/TB6/pdfs/Manuals/final_pdf_default_withcover.pdf).
- Universal Declaration of Human Rights , 1948 (www.ohchr.org/en/udhr/pages/introduction.aspx, accessed 8 August 2010).
- Programming for justice: access for all: a practitioner's guide to a human rights-

based approach to access to justice . United Nations Development Programme, Bangkok , 2005 (http://hrbportal.org/wp-content/files/1233230279_8_1_1_resfile.pdf, accessed 8 August 2010).

- Access to Justice and Rule of Law . United Nations Development Programme (www.undp.org/governance/focus_justice_law.shtml, accessed 8 August 2010).
- Chapter six: from provisions to practice: implementing the Convention: legal capacity and supported decision-making. In: Handbook for parliamentarians on the Convention on the Rights of Persons with Disabilities. UN Enable (www.un.org/disabilities/default.asp?id=212), accessed 1 July 2010).
- Access to justice: practice note . United Nations Development Programme, 2004, (www.undp.org/governance/docs/Justice_PN_English.pdf, accessed 16 June 2010).

Уншихыг санал болгож буй материалууд

Griffo G, Ortali F, eds. Training manual on the human rights of persons with disabilities. Bologna, AIFO, 2007

(www.aifo.it/english/resources/online/books/cbr/manual_human_rights-disability-eng07.pdf, accessed 16 June 2010).

International Committee of Sports for the Deaf: www.deaflympics.com (accessed 16 June 2010).

International Sports Federation for People with Intellectual Disability: www.inas-fid.org (accessed 16 June 2010).

International Paralympic Committee: www.paralympic.org (accessed 16 June 2010).

Harnessing the power of sport for development and peace: recommendations to governments. Right to Play, 2008 (www.righttoplay.com/International/news-and-media/Documents/Final%20Report%20revised%202010.pdf, accessed 16 June 2010).

Special Olympics International: www.specialolympics.org (accessed 16 June 2010).

Thomas M, Thomas MJ. Addressing concerns of women with disabilities in CBR . UN ESCAP Workshop on Women and Disability. Bangkok: Thailand, 2003 (www.worldenable.net/wadbangkok2003/paperthomas.htm, accessed 17 June 2010).

UNESCAP. Focus on ability, celebrate diversity: highlights of the Asian and Pacific Decade of Disabled Persons, 1993–2002. Social Policy Paper No. 13, 2003 (www.unescap.org/esid/psis/publications/spps/13/Focus-T.pdf, accessed 16 June 2010).

United Nations Sport for Development and Peace: www.un.org/themes/sport/ (accessed 16 June 2010).

ХОТСЗ ХАНДЛАГЫН МАТРИЦ

